



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

## **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	<b>1</b>
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	<b>2-10</b>
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	<b>11-42</b>
<hr/>	
<i>1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа 2022.12.30-ны өдөр, Засгийн газар 2023.01.18-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<b>11-18</b>
<i>2.“Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<b>18</b>
<i>3.“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	<b>19</b>
<i>4.“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<b>19-27</b>
<i>5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт</i>	<b>27-43</b>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 06 дугаар сарын 20-ны өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 29 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Д.Ганбат;  
Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Д.Цогтбаатар, Б.Энх-Амгалан;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг, Ц.Сэргэлэн;  
Тасалсан: Ц.Сандаг-Очир.

**Нэг.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2022.12.30-ны өдөр, Засгийн газар 2023.01.18-ны өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, шинжээч М.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар танилцуулав.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүний өргөн барьсан төслийг Засгийн газраас өргөн барьсан төсөлтэй нэгтгэн явуулъя гэсэн горимын санал гаргав.

**Б.Энхбаяр:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11

63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуулийн төслүүдийг нэгтгэн хэлэлцэхээр тогтов.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Х.Нямбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хариулж, тайлбар хийв.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Энхбаяр:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн “нөлөө бүхий хувьцаа” гэсний дараа “эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн Тайлбар хэсгийн “17.1-д заасан” гэсний дараа “томилогдох” гэж нэмж, “18.1.1-д заасан төрийн захиргааны” гэснийг “18.2-т заасан” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.3 дахь хэсгийн “зөрчсөн нь” гэсний дараа “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол тухайн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Х.Нямбаатар нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хариулж, тайлбар хийв.

*Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайханаас гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Энхбаяр:** Төслийн 1 дүгээр зүйлийн “тайлбар” гэснээс “дагавар” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “хамтран амьдрагчийн” гэсний дараа “одоо хамтран амьдарч байгаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Б.Энхбаяр:** 2.Төслийн 1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “хамтран амьдрагчийн” гэсний дараа “одоо хамтран амьдарч байгаа” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулав.*

### Найруулгын санал

**Б.Энхбаяр:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.1 дэх хэсгийн “Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, “хөтөлбөр” гэсний дараах “эсхүл” гэснийг хасаж, 20<sup>1</sup>.3, 29.6 дахь хэсгийн “20<sup>1</sup> дүгээр зүйлд” гэснийг “20<sup>1</sup>.1, 20<sup>1</sup>.2 дахь хэсэгт” гэж өөрчилж, мөн 29.6 дахь хэсгийн “төр,” гэснийг хасаж, төслийн 2 дугаар зүйлийн “мөн хэсгийн “дарга,”” гэсний өмнө “байгууллагын” гэж, “тэдгээрийн” гэсний дараа “тэргүүн дэд дарга, дэд дарга” гэж, “орлогч” гэсний дараа “дарга” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 0  
Бүгд: 11  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 0  
Бүгд: 11  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Б.Энхбаяр:** 1.Төслийн 1 дүгээр зүйлийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний” гэснийг “2023 оны 10 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 1  
Бүгд: 11  
90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

**1 дүгээр зүйл.**2023 оны ... сарын...-ны өдөр баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлж байгуулагдсан уг хуулийн 20<sup>1</sup>.1-д хамаарах гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэвээр байна гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

### Найруулгын санал

**Б.Энхбаяр:** 1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.*

*Хоёр. “Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц”-д нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаая гэсэн горимын санал гаргав.

**Б.Энхбаяр:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 0  
Бүгд: 11  
100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.** *“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол”-ыг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Зам, тээврийн хөгжлийн яамны Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, мөн газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын албаны дарга П.Ганболд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч Ш.Цолмон нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Энхбаяр хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаая гэсэн горимын санал гаргав.

**Б.Энхбаяр:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	0
Бүгд:	11

100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 16 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

**Дөрөв.** *“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга З.Баасанням, Судалгаа шинжилгээний албаны дарга Ц.Шинэбаяр, мөн албаны ажилтан Л.Хангарьд, Мөрдөн шалгах хэлтсийн Гуравдугаар албаны дарга Ч.Жаргалбаатар, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга Д.Дуламсүрэн, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга Б.Баярсайхан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, мөн газрын ахлах шинжээч Ш.Цолмон, “Трансперенси Интернэшнл-Монгол” НҮТББ-ын гүйцэтгэх захирал Л.Төр-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.



Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Ш.Раднаасэд, Ш.Адъяаа нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар үг хэлэв.

**Б.Энхбаяр:** “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	0
Бүгд:	11

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

***Нэг.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт  
Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай  
Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, Хууль зүйн байнгын хороо хариуцсан референт П.Хулан нар байлцав.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн танилцуулав.

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Сүхбаатар, Ц.Мөнх-Оргил, Ш.Раднаасэд, Б.Баттөмөр, Ш.Адъяаа, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Пүрэвдорж, Ц.Мөнх-Оргил нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82.2.1-д заасны дагуу санал хураалт явуулав.*

**Б.Энхбаяр:** 1.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин.” Заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн”, гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн”, гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн”, гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3

Бүгд: 11  
72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад “Газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин, 1 тонн, 285 000” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.*

*Хуралдаан 2 цаг 11 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 40 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн  
Чингис хаан” танхим 15 цаг 29 минут

### **БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Энхбаяр:** Байнгын хорооны гишүүдийнхээ амгаланг айлтгая. Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул нээснийг мэдэгдье ээ.

Байнгын хорооны ирцийг танилцуулъя. Энхбаяр гишүүн ирсэн байна, Адьяаа гишүүн ирсэн байна, Бат-Амгалан гишүүн гадаадад томилолттой, Бямбацогт гишүүн гадаадад томилолттой, Ганбат гишүүн гадаадад томилолттой байгаа юм байна. Дэлгэрсайхан гишүүн ирсэн байна. Мөнхбаатар гишүүн ирсэн байна, Мөнх-Оргил гишүүн ирсэн байна, Мөнхцэцэг гишүүн өвчтэй, Нямбаатар гишүүн ирсэн байна, Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Раднаасэд гишүүн ирсэн байна, Сүхбаатар гишүүн ирсэн байна, Сэргэлэн гишүүн өвчтэй, Учрал гишүүн ирсэн байна, Б.Энх-Амгалан гишүүн гадаад томилолттой байгаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Адьяаагаас 2022 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын ар 11-ний өдөр тус тус өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлгийг явуулна.

2.Олон улсын иргэний нисэхийн эсрэг бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг Соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газраас 2023 оны 5 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг.

3.Агаарын хөлгийг бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг Соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Засгийн газраас 2023 оны 5 сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг.

4.Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газраас 2023 оны 6 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн хэлэлцэх эсэх асуудал.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 4 дүгээр дүгнэлт гэсэн ийм асуудлууд байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар танилцуулна.

Сүхбаатар гишүүнийг урьж байна.

**Үүнд:**

**Ж.Сүхбаатар:** Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлсэн Хууль зүйн байнгын хороонд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаагаас 2022 оны 12 сарын 30-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд тус тус өргөн мэдүүлсэн Нийтийн алба нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар нэгтгэн хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Б.Пүрэвдорж нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан болно оо.

Ажлын хэсэг хуулийн төслийг нэгтгэхдээ 2023 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд суурилсан болно. Ажлын хэсгийн зүгээс зарчмын зөрүүтэй 3, найруулгын нэг багц санал хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хүрээнд зарчмын зөрүүтэй 2 саналыг бэлтгэлээ.

Төслийн 1, 3 дугаар зүйлд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмших гэснийг тодорхой болгох үүднээс нөлөө бүхий хувьцаа эзэмшигч түүний эцсийн өмчлөгч гэж өөрчилж мөн зүйлийн төрийн албаны тухай хуулийн 17.1-д заасан Төрийн албан тушаалтан гэсний өмнө сумын сонгох сонгогдох эрхийг хангах үүднээс томилогдох гэж нэмэх,

18.1.1-д заасан төрийн захиргааны гэснийг 18.2-т гэж өөрчлөх, мөн төсөлд дурдсан хориглолт хязгаарлалтыг зөрчсөн нь албан тушаалаас чөлөөлөх огцруулах эргүүлэн татах үндэслэл болно гэж заасныг Монгол Улсын Үндсэн холбогдох бусад хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт шүүхийн хүчин төгөлдөр шийдэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол гэж тодруулан заах саналыг гаргалаа.

Нэгтгэсэн төслийн хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Адъяаагаас тус хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаалтны аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхийг хориглохоор нэмсэн заалт нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслийн 20.1 иттрих 4 дүгээр зүйлд агуулгаараа давхардаж байгаа гэж үзэж саналыг нэгтгэж бэлтгэсэн болно.

Хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд хүчин төгөлдөр болохоос өмнө уг хуулийн 20.1<sup>2</sup>-т заасан этгээд нь 2023 оны 7 дугаар сарын 1-ний өдөр холбогдох эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэж ажлаас чөлөөлөх арга хэмжээ авна гэж заасныг 2023 оны 10 дугаар сарын 1-ний өдөр болон хугацааг хойшлуулж буцаан хэрэгдэхгүй байх зарчмын үүднээс энэ хууль батлагдахаас өмнө хууль тогтоомжийн дагуу



байгуулагдсан 20.1.<sup>1</sup> иттрих нэгд хамаарах гэрээ хэлцэл хүчин төгөлдөр хэвээрээ байх агуулга бүхий 1 дүгээр зүйлийг шинээр нэмсэн болно. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн нэгтгэсэн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа. Тэгээд энэ 2 төслийг нэгтгээд 1 төсөл болгож байгаа учраас тэгээд энэ хуулийн төсөлд суурилсан Засгийн газрын хуулийн төсөлд суурилсан зөвшөөрч байгаа эсэх талаар горимын санал хураалгахаар ийм санал байгаа.

**Б.Энхбаяр:** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.24-д нэг асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн байгаа бөгөөд хууль санаачлагч нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатад нэгтгэн 1 төсөл болгож, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар хэрвээ ийнхүү нэгтгэхийг зөвшөөрөөгүй бол тус тусад нь санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ гэж заасны дагуу ажлын хэсгийн ахлагчаас гаргасан горимын саналын дагуу хуулиудыг нэгтгэн Засгийн газраас өргөн барьсан дээр суурилж хэлэлцье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

63.6 хувиар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Б.Баярсайхан АТГ-ын Хяналт шалгалт дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт дүн шинжилгээний албаны дарга, Ш.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, М.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын шинжээч гэсэн албан тушаалтнууд хуралдаанд оролцож байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Үгүй та чинь санаачлагч шүү дээ. Өөрөө санаачлагч өөрөө өөрөөсөө асуухгүй шүү дээ та чинь. Үгүй энэ өөрчилсөн хүнээсээ асуухгүй шүү дээ. Хамтарсан юм чинь юм чинь үгүй хамтарсан юм чинь та асууж болно. Энэ өөрчилчихсөн байгаа байхгүй юу харин тийм асууж болно яагаад гэвэл. Адьшаа гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяа:** Баярлалаа энэ энэ 2 хуулийн төслийг нэгтгэн хэлэлцэхийг би дэмжиж байна. Тэгээд энэ дээр энэ 1 дүгээр зүйл дээр нэг асуулт асууя аа. Энэ нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гэснийг эцсийн өмчлөгч гэдэг утгаараа ер нь яагаад ингэж оруулж ирсэн бэ? Ажлын хэсгээс нөлөө бүхий этгээдүүд байж байж энэ өнөөдөр энэ ашиг сонирхлын зөрчил түүнчлэн өнөөдөр энэ хулгай луйврын асуудал, энэ төрийн өндөр албан

тушаалтнуудын энэ нөлөө бүхий хүмүүс нь энэ оролцох оролцоог ингээд хязгаарлаад эцэст нь эцэслэн өмчлөгч гэдэг ийм юман дээр авч ирж байгаа нь энэ хуулийн үзэл баримтлалын хувьд бас ийм зөрчилдсөн ийм асуудал оруулж ирсэн гэж үзэж байна. Яагаад гэхээр өнөөдөр нөлөө бүхий этгээдүүд энд байж байж энэ хуулийн чинь мөн чанар, үйлчлэх хүрээ, энэ нийгмээс шаардаад байгаа шударга ёсны асуудал, энэ 30 жилийн хулгай луйвар, энэ төрийн өмч хөрөнгийг иддэг, уудаг энэ асуудал чинь энэ нөлөө бүхий этгээдүүдийг нь хасчхаад зөвхөн эцсийн өмчлөгч гэхээр хэнд хариуцлага хүлээх асуудал тодорхой бус байна. Энэ талаар бол ажлын хэсгээс тодруулга авъя аа.

**Б.Энхбаяр:** АТГ-ын санал биз дээ энэ чинь. Сүхбаатар гишүүн хариулъя. Ажлын хэсгийн ахлагч.

**Ж.Сүхбаатар:** Үгүй яах вэ энэ АТГ-ын саналаас гадна би ажлын хэсэг дээр л ярьсан юм л даа. Хасаагүй харин нөгөө өргөтгөж байгаа юм. Яагаад нөлөө бүхий хувьцаа эзэмшигч гээд хэлчихээр нөгөө эцсийн өмчлөгч чинь мэдэгдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Ингээд явсаар байгаад сүүлд нь эцсийн өмчлөгч байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр харин ч энэ эцсийн өмчлөгч нь сугарч үлдэх гээд байсныг нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигч дээр нэмэх нь түүний эцсийн өмчлөгч гэж зааж бүүр ингээд өргөтгөөд бүүр найдвартай юугаар нь хийгээд, АТГ-ын манай нөхдүүд тийм асуудал үүсдэг юм гээд ингээд бүүр хасах байтугай, бүр баталгаажуулаад, бүр цаад талын юмыг нь ингээд оруулж байгаа юм.

**Б.Энхбаяр:** Нямбаатар сайд ийм микрофоныг.

**Х.Нямбаатар:** Энэ ийм санаа орж ирж байгаа шүү дээ. Нөгөө 2 дугаар зүйлийн 20.<sup>1</sup> зүйлд заасныг зөрчсөн нь албан тушаалтныг чөлөөлөх, огцруулах эргүүлэн татах үндэслэл болно гэж байгаа юм. Тэгэхээр энэ эргүүлэн татаж чөлөөлөх үндэслэл болно гэж байгаа юм.

Тэгэхээр, энийг, жишээлбэл, улс төрд нөлөө бүхий албан тушаалтнууд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлаас томилогддог, чөлөөлөгддөг ийм байгууллагын тухайд яаж бусад нөгөө нэг холбогдох хуулиудтай нь уяж өгсөн юм. Өөрөөр хэлбэл Үндсэн хууль зөрчсөн гэдэг үндэслэл гэж үзэхэд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль процессынхоо хуультай яаж уяж шийдэл гаргахгүй гэж байгаа юм бэ?

Энийг нэг ажлын хэсэг хариулаад өгөөч.

**Б.Энхбаяр:** Сүхбаатар гишүүн хариулъя. Тэгэхээр энэ асуудал түрүүн хэн Байнгын хороон даргын хэлээд байгаа л тэр л дээ. Нөгөө 1 дүгээр зүйл дээр биш дараагийн 3 дугаар саналын асуудал дээр яг энэ асуудал гарч ирж байгаа юм. Тэгээд яах вэ яг холбогдох хуулиудыг нь нэрлээд заачхаж байгаа юм. Энэ бол асуудал үүсгэж байгаа л даа. Энэ чинь нөгөө өөрөөс нь шалтгаалахгүй нөгөө өөрийнх нь хамааралтай этгээд энийг зөрчсөн асуудал болонгуут шууд үндэслэл болчихгүй.

Тэр бусад холбогдох хуулиуд дээр яг энийг зохицуулчихсан байгаа учраас тэр хуулиудыг нь нэрлэж тоочиж, заасан байгаа.

Жишээлбэл одоо Ерөнхийлөгч, Их Хурлын гишүүд, Засаг дарга, Засгийн газрын гишүүд гэхээр Үндсэн хууль, Их Хурлын тухай хууль, Ерөнхийлөгчийн хууль, Засгийн газрын хууль, нэгжийн хуульд заасны дагуу тэр Цэцийн дүгнэлт шүүхийн хүчин төгөлдөр шийдэх тогтоол гэм буруутай нь тогтоогдсон тул тухайн гэдгээр нь тэр чинь угаасаа тэгж зохицуулалттай учраас тэрүүгээр нь зааж нэрлэе гээд ингээд 3 дугаар санал дээр хураах юм байгаа юм.

Тэгэхээр саяынх нэгийнх бол нэгийнх бол биш.

**Б.Энхбаяр:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ажлын хэсгээс гаргаж байгаа зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн “нөлөө бүхий хувьцаа” гэсний дараа “эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч” гэж нэмэх.

Санал хураалт.

63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн Тайлбар хэсгийн “17.1-д заасан” гэсний дараа “томилогдох” гэж нэмж, “18.1.1-д заасан төрийн захиргааны” гэснийг “18.2-т заасан” гэж өөрчлөх.

Санал хураалт.

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.3 дахь хэсгийн “зөрчсөн нь” гэсний дараа “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол тухайн” гэж нэмэх.

Санал хураалт.

Дэлгэрсайхан гишүүн үг хэлнэ. Сайн санал хураалтыг цуцалж байгаа юм. Асуулт асууна, тэ.

**Б.Дэлгэрсайхан:** Энэ хууль санаачлагчаас нэг юм асууя.

Энэ 20.3-ын энэ хуулийн 20.2 дахь хэсэг 20.<sup>1</sup>1 дүгээр зүйлд заасныг зөрчсөн нь албан тушаалтныг чөлөөлөх огцруулах, эргүүлэн татах үндэслэл болно гээд. Тэгээд тэр доор тайлбар дээр нь энэ зүйлийн хүүхэд гэдэгт эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн төрсөн болоод дагавар, үрчлэн авсан хүүхэд гэж ойлгоно гэж байгаа юм. Амьдрал баян. Би нэг юмыг асууя. Энэ одоо жишээлбэл энэ дагавар хүүхэд, ингээд янз бүрийн энэ дээр зааснаар чинь нэг албан тушаал юу байдаг юм энэ чинь өөрийнхөө мөнчигрөөр ингээд янз бүрийн албан тушаал бас бизнес ингээд эрхлэх эрхийг нь ингээд тэс хөндлөнгийн үнээр хориглоод хаячхаж байна шүү дээ энэ чинь болохгүй шүү дээ энэ чинь, айн? Үгүй тэгээд энэ арай хэцүү. Энэ одоо бас поп гэхэд арай дэндүү поп байна та нар. Надад дагавар хүүхэд байхгүй л дээ. Тэгэхдээ үгүй нээрээ энэ чинь болохгүй шүү дээ энэ чинь. Хүний хувь заяагаар ингээж тоглож болохгүй шүү дээ энэ чинь. Энийг та нар энийгээ боль гэж хэлмээр байгаа юм. Тэгээд хэн хариулах юм. Энэ арай болохгүй.

**Б.Энхбаяр:** Сүхбаатар гишүүн хариулъя.

**Ж.Сүхбаатар:** Нэгдүгээрт энэ байгаа. Яах вэ Засгийн газраас оруулж ирсэн төсөл дээр бол ингээд явж байгаа. Гэхдээ бид бол энийг яг таны хэлдгээр байна шүү дээ нэг талын биш болгоод юу гэсэн гэхээр шууд эргүүлэн татах үндэслэл нөгөө хүн маань өөрөөс нь энэ гишүүн ч гэдэг юм уу тэр Засаг дарга, Засгийн газрын гишүүнээс хамаарахгүйгээр өөрөө ямар нэгэн хөнгөлөлт чөлөөлөлт янз бүрийн юманд ингээд хамрагдаад явчхангуут шууд үндэслэл бас болно гэж заасныг нь харин ч бид тэр 3 дугаар заалт энэ юун дээрээ ийм ийм хуульд заасны дагуу энийг нь хариуцлага хүлээлгэх асуудлыг шийднэ гээд арай өөрчилсөн байж байгаа.

Тэр ер нь бол яах вэ? Хүүхэд гэдэгт бол тэгээд л нөгөө Гэр бүлийн хууль,



хүүхдийн юугаараа ингээд л тэр чинь төрснөөс ялгаагүй дагавар үрчлэн авсан эд нар гэдгийг чинь ингээд оруулчхаж байгаа байхгүй юу?

Тэгэхээр ер нь бол сонирхлын зөрчлийн асуудал чинь бол гол нь зохицуулалт нь бол ганцхан төрсөн гэдгээр нь бол яахгүйгээр яг ингэж л авсан байгаа шүү дээ. Тэгээд амьдрал дээр ямар кэйсүүд байх вэ гэхээр төрсөн нь илүү сонирхлын зөрчилтэй байна. Үрчлэн авсан дагавар хүүхэддээ хайргүй учраас бас тэгээд юм хумаа өгсөн нь хамаагүй эд нар гэж бодож болохгүй л байх л даа гол нь.

Сонирхлын хувьд бол тэр чинь гэр бүлийнх нь хүүхэд гэж л тооцно шүү дээ. Тэрнээс чи манай дагавар хүүхэд учраас чи арай бага эрхтэй миний ашиг сонирхолд бага холбогдоно гэж хэлж болохгүй л байгаа байхгүй юу.

Яах вэ ер нь бусад заалт нь ч гэсэн тийм л байгаа шүү дээ. Төрсөн хүүхэд гэдэг чинь ялгаагүй л байгаа.

**Б.Энхбаяр:** Дэлгэрсайхан гишүүн тодруулж асууя. Нэг минут.

**Б.Дэлгэрсайхан:** Нэгдүгээрт бол энэ аль ч ажлын энэ хууль санаачилсан хэсгээс ч бай, Засгийн газрын ч бай, Адьшаа гишүүний санаачилсан хэсгээс ч юм уу I дүгээрт дагавар гэдгийг хасмаар байгаа юм.

Хоёрдугаарт эхнэр, нөхөр, хамтран амьдрагчийн хамт байгаа гэж оруулахгүй бол нэг гэрт хамт байгаа гэж оруулахгүй бол хүүхдүүд чинь байна шүү дээ одоо ингээд бие даагаад гадагш дотогшоо яваад нүд ам нь нээгдээд энд тэнд очсон хойноо янз бүрийн бизнес хийдэг. Орчин шал өөр болчихсон шүү дээ. Бизнес хүртэл онлайн болчихоод ингээд одоо бид нар хянаж чадахаа байчихсан.

Тэгэхлээр зэрэг яг ингээд хамтран амьдарч байгаа гэж оруулахгүй бол наадах чинь ахиад л бас болохгүй. Хүний

эрх зөрчиж байгаа байхгүй юу. Одоо үгэнд ордог хүүхэд хэн байгаа юм тийм биз дээ? Арван хэдтэй сургуульд байгаа хүүхэд.

**Б.Энхбаяр:** Энэ асуудлаараа Дэлгэрсайхан гишүүн бас зарчмын зөрөөтэй санал гаргаж санал хураалгах эрхтэй, бүрэн эрхтэй байгаа. Нямбаатар гишүүн асуултаа асууя.

**Х.Нямбаатар:** Одоо бид нар чинь энэ нөгөө зарчмын зөрөөтэй саналын томъёоллынхоо 3 дээр яг хураах гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энд нэг ийм юу оруулахгүй бол бичилт оруулахгүй бол болохгүй байна л гэж хэлэх гэсэн юм. Би түрүүн ч гэсэн үгэндээ хэлсэн юм.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай гээд таслал тавиад бусад холбогдох хуульд заасны дагуу гэж оруулбал энэ заалт өөрөө амилна л гэсэн үг. Тэгэхгүй болохоор, тийм тийм. Тэгэхээр би ийм найруулгын өөрчлөлт оруулаад энэ саналыг хураалгамаар байгаа юм.

**Б.Энхбаяр:** Энэ сая Нямбаатар гишүүний асуултыг ажлын хэсгийн ахлагч юу үзэж байна Сүхбаатар гишүүн.

**Ж.Сүхбаатар:** Тэгье тэр нөгөө нэгжийн удирдлагын тухай хууль, холбогдох бусад хуульд заасны дагуу гээд ингээд бид нар энэ саналыг тэгээд санал хураагаад явчихъя. Зүгээр ер нь тэр хэний хувьд бол жоохон эвдэгдэнэ шүү дээ. Дэлгэрсайхан гишүүн ээ дагаврыг нь ингээд хасчихлаа гэхэд тэгвэл үрчлэн авсныг нь хасах уу гэдэг асуудал үүсээд. Энэ чинь ер нь анх Засгийн газрын анх яригдсан юм бол бүүр өргөн хүрээний юм байсан шүү дээ. Хамаарал бүхий этгээд энэ гол юм нь юу юм бэ гэхээр энэ хүмүүс чинь нөгөө төрсөн хүүхэд эхнэртэйгээсээ гадна хамаарал бүхий хүмүүстээ хөрөнгө мөнгөө тарааж байрлуулаад авлигаас зугтах сонирхлын зөрчлөө нуух гэдэг ийм оролдлого байгаад их өргөн хүрээнд байсныг нь хумиад бүүр харин эхнэр,

нөхөр, хамтран амьдрагчийн төрсөн дагавар үрчлээ авсан гэдэг чинь уг нь их багасгасан хүрээ байхгүй юу. Анх бол бүүр энэ чинь төрөл садны хүмүүсийг нь оруулж байсан юм шүү дээ.

Тэгэхээр одоо ингээд дагавар хүүхдийг нь ганцхан таслаад авчихна гэхээр үрчлэн авсан нь яах юм. Төрсний гээд ингээд явахаар энэ хуулийн чинь агуулга бол улам хумигдаад ач холбогдол нь буурна гэдэг л асуудал байгаа юм.

**Б.Энхбаяр:** Тэгвэл ажлын хэсгийн ахлагч зөвшөөрч байгаа юм байна. Гишүүд асуулт асууж дууслаа. Ажлын хэсгийн ахлагч зөвшөөрч байгаа учраас би сая томьёоллыг дахин уншъя.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.3 дахь хэсгийн “зөрчсөн нь” гэсний дараа “Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, холбогдох бусад заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор гэм буруутай нь тогтоогдсон бол тухайн” гэж нэмэх.

Санал хураалт.

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Саяын 1 дүгээр зүйл дээр Дэлгэрсайхан гишүүн санал гаргая гээд байсан уу? Дэлгэрсайхан гишүүн 1 дүгээр зүйл дээр санал гаргасан байна.

Дэлгэрсайхан гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг уншиж сонсгоё.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “тайлбар” гэснээс “дагавар” гэдгийг хасах санал хураалт. 63.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дэлгэрсайхан гишүүнээс гаргасан 2 дахь зарчмын зөрүүтэй санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн тайлбар гэдэгт хамтран амьдрагчийн гэсний дараа одоо хамтран амьдарч байгаа гэж нэмэх гэсэн санал гаргасан байна. Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй.

Адьяаа гишүүний микрофоныг өгье.

**Ш.Адьяаа:** Би уул нь дэмжсэн санал өгсөн юм энэ төхөөрөмж ажилласангүй дахиж санал хураалгаж өгнө үү? Сая энэ Дэлгэрсайханы.

**Б.Энхбаяр:** Адьяаа гишүүнээс гаргасан горимын саналаар санал хураалгая. Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэдэг санал хураалтаар санал хураалт явуулъя.

Санал хураалт. 54.5 хувийн саналаар саяын санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Түрүүний хэлсэн Дэлгэрсайхан гишүүнээс гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт “хамтран амьдрагчийн” гэсний дараа “одоо хамтран амьдарч байгаа” гэж нэмэх гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

1 дүгээр зүйл дээр санал хураалт дууслаа.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрүүтэй санал.

Хоёрдугаар зүйл дээр энэ алга байна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Санал гарсан санал алга байна.

Ажлын хэсгээс гаргасан санал алга байна. Гишүүдээс бичгээр гаргасан санал алга байна. Хуулийн төслийн ажлын хэсгээс гаргасан найруулгын саналаар санал хураалт явуулъя.

Найруулгын санал нэг.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 20<sup>1</sup>.1 дэх хэсгийн “Засаг даргын албан тушаал эрхэлж байгаа хүн” гэснийг “Засаг дарга” гэж өөрчилж, “хөтөлбөр” гэсний дараах “эсхүл” гэснийг хасаж, 20<sup>1</sup>.3, 29.6 дахь хэсгийн “20<sup>1</sup> дүгээр зүйлд” гэснийг “20<sup>1</sup>.1, 20<sup>1</sup>.2 дахь хэсэгт” гэж өөрчилж, мөн 29.6 дахь хэсгийн “төр,” гэснийг хасаж, төслийн 2 дугаар зүйлийн “мөн хэсгийн “дарга,”” гэсний өмнө “байгууллагын” гэж, “тэдгээрийн” гэсний дараа “тэргүүн дэд дарга, дэд дарга” гэж, “орлогч” гэсний дараа “дарга” гэж нэмэх.

Санал хураалт.

100 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх

Санал хураалт.

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна.

Ажлын хэсгээс гаргасан санал зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний” гэснийг “2023 оны 10 дугаар сарын 01-ний” гэж өөрчлөх.

Санал хураалт.

90.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмэх:

1 дүгээр зүйл.2023 оны ... сарын...-ны өдөр баталсан Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлж байгуулагдсан уг хуулийн 20<sup>1</sup>.1-д хамаарах гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэвээр байна.

Санал хураалт.

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын саналаар санал хураалт явуулъя.

1.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн агуулга, зарчмыг хөндөхгүйгээр төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх.

Санал хураалт.

72.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар танилцуулна.

16.05 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Энэ олон улсын хэлэлцэх эсэх асуудал дээр бас Мөнх-Оргил гишүүн бас нэлээн тэр яг олон улсынх нь гэрээнд байгаа агуулга томъёоллоор нь бас буулгаагүй байна гэдэг асуудлыг хөндөж ярьж байсан. Хэлэлцэх эсэх асуудал дээр ярьж байсан. Ингээд энэ асуудлыг бас судалж үзэхэд энэ яг тэр олон улсын гэрээнийхээ агуулгаас бас өөр болоод орчуулагдаад ороод ирчихсэн ийм нөхцөл байдлууд байсан. Нөгөө талаас бас Эрүүгийн хуульд бас байхгүй ял шийтгэлийн интервал хэрэглээд оруулаад ирчихсэн ийм асуудал байсан. Тийм учраас энийг Засгийн газартай бас ярьсан. Хууль санаачлагчтай. Хууль санаачлагчид нь буцаая гэдэг зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаж байгаа. Засгийн газраас 2023 оны 5 сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенцод нэгдэн орсныг Соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлагчид нь буцаая гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

100 хувийн саналаар санал дэмжигдлээ. Санал, дүгнэлтийг хэн танилцуулах вэ? Дэлгэрсайхан гишүүн танилцуулчих уу? Санал дүгнэлт санал дүгнэлтийг.

16.07 цагт

Дараагийн асуудалдаа оръё. Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын



*нэмэлт протоколыг Соёрхон батлах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.*

*Төслийг хууль санаачлагчид нь буцаах зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаж байгаа, мөн яг адилхан би санал гаргаж байна. Түрүүний үндэслэлээр.*

*Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.*

*Санал хураалт.*

*100 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Санал, дүгнэлтийг Дэлгэрсайхан гишүүн танилцуулна.*

*Дараагийн асуудалдаа орёе. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцье.*

*Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Нямбаатар танилцуулна.*

*Нямбаатар сайдын микрофон.*

**Б.Энхбаяр:** *Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,*

*Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого шинэ сэргэлтийн бодлогод үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига албан тушаалын гэмт хэргийг бууруулах, авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх зорилт дэвшүүлсэн.*

*Улсын Их Хурлаас 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжих хугацаа 2023 онд дуусаж байгаа бөгөөд уг хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дагаврын*

*үнэлгээг хэлэлцэхэд төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт дунджаар 75 хувьтай байна.*

*Ийнхүү дээрх хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр Монгол Улсын авлигатай тэмцэх ажилд ахиц гарч тодорхой үр дүнгээ өгч байгаа бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан авлига албан тушаалын гэмт хэргийн ялын бодлогыг чангаруулж, хэрэгжилтийг сайжруулах, шүүх, прокурор, сахиулах байгууллагын бие даасан хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигатай тэмцэхэд иргэд олон нийт, хувийн хэвшлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, төсөв, санхүүгийн ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэх, өндөржүүлэх зэрэг энэхүү үндэсний хөтөлбөрөөр хараахан хүрээгүй, үргэлжлүүлэн сайжруулах шаардлагатай зарим үйл ажиллагаа арга хэмжээ хүлээгдэж байна. Түүнчлэн Трансперенси интернэйшал ОУБ-аас жил бүр боловсруулан гаргадаг авлигын төсөөллийн дүнгээр 180 орноос Монгол Улс 2017 онд 103, 2018 онд 93, 2019 онд 106, 2020 онд 35 оноо авч, 111 дүгээр байр, 2022 онд 35 оноо авч 110, 2022 онд 33 оноо авч 116 дугаар байрт эрэмбэлэгдээд байна.*

*Энэхүү авлигын төсөөллийн индекс нь манай улсын авлигын түвшинд өгч буй ОУБ-ын үнэлгээ бөгөөд Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлан хэрэгжүүлснээр энэхүү үнэлгээнд ахиц гаргах ач холбогдолтой юм. Улс төрд нөлөө бүхий этгээд төрийн албан тушаалтнууд эрх мэдлээ урвуулан ашиглаж бусдад давуу байдал олгох нь даамжирч, иргэдийн боломжийг хязгаарлан, эдийн засаг, нийгэм, боловсрол, эрүүл мэнд зэрэг бүхий л салбарт тэгш бус байдлыг үүсгээд байна. Энэ нь улс орны эрсдэлийг нэмэгдүүлэн олон улсын байгууллагуудын үнэлгээнд муугаар нөлөөлж улмаар иргэдийн төрд итгэх итгэлийг бууруулахад хүргэв. Албан тушаал эрх мэдлээ урвуулан ашиглах эдгээр зохисгүй нөхцөл байдлыг таслан*

зогсоох, авлигатай тэмцэх тэмцлийг үр дүнтэй хэрэгжүүлэх улмаар иргэдийн төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэхийн тулд урт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийг бодлого төлөвлөгөөтэй үргэлжлүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ийм дээр бодлогын баримт бичигт тусгасан зорилтыг хэрэгжүүлэх авлигын төсөөллийн индекст ахиц гаргах авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор дараагийн хөтөлбөрийг батлах хэрэгцээ, шаардлага үүссэн. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу хөгжлийн зорилтот хөтөлбөрт хамаарч байгаа болно.

Хөтөлбөрийн төслийг АТГ-ын тушаалаар тус байгуулсан ажлын хэсэг боловсруулсан бөгөөд хөтөлбөрийн төсөлд авлигатай тэмцэх талаарх төрийн бодлого, эрх зүйн орчин, үйл ажиллагааг цогцоор нь авч үзэн шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх зарчмыг баримтлан боловсруулахын зэрэгцээ шинэ сэргэлтийн бодлого Засгийн газраас 2023 онд зарласан авлигатай тэмцэх 5 ш ажиллагаа зэрэг арга хэмжээтэй уялдуулан тодорхойлсон болно.

Хөтөлбөрийн төсөлд нийт 10 зорилго, 46 зорилт, түүнийг хэрэгжүүлэх 203 үйл ажиллагааг тусгалаа.

Хөтөлбөрийн хүрээнд тодорхойлсон нийт үйл ажиллагааг төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, олон улсын байгууллагууд, хэвлэл мэдээлэл, иргэдийн оролцоо, хамтын ажиллагаанд түшиглэн хэрэгжүүлэх юм. Үр дүнд нь авлигын индекст ахиц гарах, улсын төсөв тэлэх, иргэдийн төрийн байгууллага, төрд итгэх итгэлийн түвшин нэмэгдэх, иргэдийн орлого өсөж, авлигыг үл тэвчих соёл шүгэл үлээх тогтолцоо бэхэжсэн байна гэж үзэж байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг батлах Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл

баримтлал тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

**Б.Энхбаяр:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Д.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, С.Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах шинжээч, Баасанням АТГ-ын Тамгын хэлтсийн дарга эрхэлсэн комиссар, Шинэбаяр АТГ-ын Судалгаа, шинжилгээний албаны дарга эрхэлсэн комиссар. Жаргалбаатар АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн 3 дугаар албаны дарга ахлах комиссар, Дуламсүрэн АТГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн ажлын албаны дарга, ахлах комиссар, Хангарди АТГ-ын судалгаа, шинжилгээний албаны ажилтан, комиссар, Баярсайхан АТГ-ын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны дарга ахлах комиссар, Төр-Од Трансперенси интернэшил Монгол ТББ-ын гүйцэтгэх захирал гэсэн албан тушаалтнууд оролцож байна.

Тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Адьшаа гишүүнээр тасаллаа, Раднаасэд гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

**Д.Цогтбаатар:** Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Би тогтоолын төслийг дэмжиж байгаа. Тэгээд энэнтэй холбогдуулаад нэг юмыг тал талдаа л нэг анхаарах хэрэгтэй байгаад байна. Юу гэвэл ер нь бол авлигатай тэмцэнэ гэдэг дээр бол Монголын нийгэм төр аль аль талаасаа их зоримог ажиллаж байгаа. Тэгэхдээ үр дүн хамгийн чухал. Яриа маань их байна. Энэ дээр үр дүн гаргах

ёстой. Тэгээд би үр дүн дээр нэг зүйлийг хэлмээр байгаа юм. Энэ улс төрийн болон ер нь төрийн хамгийн дээр байгаа албан тушаалтнуудыг байнга шалгаж хянаж олон нийтийн хараа хяналтад тэртээ тэргүй хүссэн хүсээгүй байж байгаа энэ дээр бол хараа хяналт хатуу хэвээрээ байх ёстой.

Гэхдээ яг энэ дээр ингээд төвлөрөөд олон нийтийн бүх анхаарал энэ юм руу явж байх хооронд энэ дунд түвшинд чинь бол ер нь бол найгаа алдаж байгаа юм шиг байна шүү. Зүгээр л энгийн иргэд ярьж ажил явахгүй байна. Шийдвэр гаргахгүй байна.

Нөгөөдүүл нь нөгөө анхаарлын гадна дуран авиа болохлоор хэдэн том улс төрчид рүү нь явчхаад байдаг. Нөгөөдүүл анхаарлын гадна нэг л тайван амьтад. Хүмүүсийн ажлыг жинхэнэ сунжруулж жинхэнэ хүндрүүлж, тэгээд л гэр орныг нь очоод нэгжихлээр энэ чинь хүүхдийн мөнгөнд хүрчихээр хэмжээний мөнгө тэр дунд хэмжээний жижиг албан тушаалтнуудаас чинь гарч ирээд байна шүү дээ.

Тэгэхээр би энэ дээр миний асуух гэж байгаа юм дунд шатдаа ер нь энэнтэй яаж тэмцэж тэгээд үр дүн гаргахад ер нь яг тодорхой юу юуг хийж үр дүн гаргана гэж бодож байгаа юм. Тэрэн дээр би нэг гүйцэд хариулт авчихмаар байна.

Тэгээд нөгөө гол ярьж байгаа нь мэдээжийн хэрэг, өнөө маргаашдаа шууд, тэгээд л тийм амархан шийдэгдэхгүй байж магадгүй. Гэхдээ та нарын тэр урт хугацааны зорилго ер нь хэзээ гэхэд ямар үе шаттайгаар энэ үзүүлэлтүүдийг бууруулаад явах вэ олон улсын үзүүлэлтийг ч гэсэн. Одоо тэдэн онд гэхэд Трансперенси интернэйшнлийн энэ 116 дээр байгааг бол ийшээ авчирна. Ийм ийм юмнууд хийж байгаад энд авчирна гэж бодож байгаа гэсэн ийм тооцоонууд байгаа юу? Энэ дээр хариулт байгаа юу?

**Б.Энхбаяр:** Нямбаатар сайд хариулъя.

**Х.Нямбаатар:** Би нөгөө нэг нэлээн олон ажлын хэсэг хариуцаж байгаа тэрний нэг нь энэ Трансперенси интернэйшнл ОУБ дахь авлигын төсөөллийн индексийг бууруулах. Энэ чиглэлээр яг одоо би энд байгаа хүмүүс болон гаднын зөвлөхүүд аваад ингээд бүтэн жил ажиллаж байна. Би нэг зүйлийг яг Байнгын хорооныхоо гишүүдэд үнэн зөвөөр хариулъя гэж бодож байна. Нийтдээ 13 шалгуур үзүүлэлт дотроо 40-өөс 50 тэр шалгуур үзүүлэлтэд хуваагдаж байгаа юм. Энэ үзүүлэлтүүдийн бараг 80 орчим хувь нь яг бид нарын энэ хөтөлбөрт тусгагдсан асуудал гэхээс гадна цэвэр Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг хэрхэн нэмэгдүүлэх вэ төрийн хувийн хэвшлийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг хэрхэн нэмэгдүүлэх вэ. Эрсдэлийн үнэлгээг гаднын индикаторууд нь манайд ямархуу байдлаар өгч байгаа вэ? Дэлхийн банкны шалгуур үзүүлэлтүүдийг бид нар хэрхэн хангаж байгаа вэ гэдгээр манай авлигын төсөөллийн индексийн бараг 80 орчим хувь нь үнэлэгдэж байгаа.

Энэ 13 шалгуур үзүүлэлтээс зөвхөн нэг үзүүлэлт нь яг Хууль зүй, дотоод хэргийн яаманд харьяалж шалгуур үзүүлэлтийг гаргадаг буюу тэр байгууллага нь Ворлд жастис прожект буюу rule off law дээр манай шалгуур үзүүлэлт дээр бид түлхүү ажилладаг. Энэ дээр бид нар 3 зүйл дээр илүү фокуслаж ажиллаж байгаа.

Нэгдүгээрт захиргааны нөгөө шийдвэр гаргалтын үйл ажиллагаа улс төрөөс хэт хамааралтай байна гэдэг дээр манай шалгуур үзүүлэлтүүд унаж байгаа.

Хоёрдугаарт хувийн өмчийг хураан авахдаа хангалттай нөхөн олговор олгож байгаа эсэх гэдэг дээр бид нарын шалгуур үзүүлэлт нэлээд эрсдэлтэй байгаа.

Гуравдугаарт нь захиргааны шийдвэр гаргалтын үйл ажиллагаа бас удааширалтай байгаа. Хариу өгөх нөгөө өргөдөл гомдлын шийдвэрлэлт гэсэн энэ зүйлүүд дээр бид нар энэ Захиргааны ерөнхий хуулийг Өргөдөл гомдлын хуультай нэгтгэх талаар Их Хурал өргөн бариад хуулийн төслийг өргөн барьсан явж байгаа.

Үндсэндээ бусад бүх асуудлууд одоогийн Засгийн газрын бүтцээр Эдийн Засаг Хөгжлийн Яам энэ Трансперенси Интернэйшнал ОУБ-ын Си Пи Ай буюу шалгуур үзүүлэлтийг хангах чиглэл дээр дорвитой арга хэмжээ авч ажиллах ёстой юм байна лээ. Бид 7 хоногт 2-оос доошгүй удаа бүх шалгуур үзүүлэлт гаргадаг олон улсын байгууллагууд, тинк танкнууд, индикатор байгууллагуудтай манай Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр байгуулагдсан ажлын хэсэг түлж ажиллаж байгаа. Хамгийн сүүлд бид нар Вашингтон төвтэй Брүүкс институттай холбогдож бид ярихад танайх Дэлхийн банкны 49 шалгуур үзүүлэлт дээрээ төдийлөн хариулт өгөхгүй байна. Танай төрийн байгууллагууд олон нийтэд нээлттэй ил тод байх талаар, өөрийнхөө веб сайт болон бусад олон нийтэд мэдээлэл өгдөг энэ байгууллагуудтай харьцах тал дээрээ маш том асуудал байна гэдгийг бидэнд хэлсэн. Сүүлд бид нар бас Трансперенси интернэйшнал ОУБ-ыг үүсгэн байгуулагч Петр Агин гэдэг хүнийг ХБНГУ-аас ирж бас зөвлөгөө авч ажилласан. Бид нар бас ирэх 7 хоногуудад тодорхой энэ чиглэлийн байгууллагуудтай ажиллахаар байгаа.

Тэгэхээр бид нар Засгийн газрын түвшиндээ ч тэр Их Хурлын түвшиндээ энэ авлигатай тэмцэхэд хамгийн том ахиц дэвшил гаргана гэх гэдэг зүйл бол бизнес хувийн сектороо илүү их дэмжсэн эдийн засгаа илүү их либералчилсан энэ бодлого руу бүх шатандаа бодлогоо чиглүүлж явж байж бид нар илүү үнэлгээ авна. Тэрнээс биш яг энэ өнөөдрийн бид нарын батлуулж байгаа Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрөө бид нар

хэрэгжүүлээд Хууль зүй, дотоод хэргийн яам мөрдөх байгууллага, Авлигатай тэмцэх газар зөвхөн энэ ажлууд дээрээ урагшаа ахиц гаргаад тэр ТИ дээр бид нар 40 оноо, 50 оноо авна гэдэг бол.

**Б.Энхбаяр:** Цогтбаатар гишүүн тодруулах юм уу тодруулж асууя.

**Д.Цогтбаатар:** Сонсох гэсэн хариугаа харин авчихлаа. Яг зөв тэр Нямбаатар сайдаа. Одоо ингээд Их Хурал дээр юу өргөн барьчихсан байгаа төрийн өмчит ААН-үүдийг нөгөө тоог нь нэгийг ч нэмэхгүй байя гээд энэ яриад байгаа жинхэнэ авлигыг чинь эх сурвалж тэнд явж байгаа байхгүй юу. Тийм их мөнгө төрийн карманд эргэлдэж байгаа цагт та нар тэнд арми тавиад хянаж чадахгүй. Хулгай гэдэг чинь олноос олон би баригдахгүй гэж бодоод хүн хийх гээд байгаа байхгүй юу. Тэгэхлээр яг өөрийн чинь ярьж байгаад наадхыгаа л та нар хэрэгжүүлэх хэрэгтэй. Ойлголоо.

Хоёр дахь нь тэгэхээр би ямар ч гэсэн саналаа л хэлж байна шүү дээ тэ наад яагаад гэвэл өөрийн чинь санаа яг зөв байгаа байхгүй юу. Тэр энийгээ л эндээ бас тусгаж оруулах ёстой 2 дахь юм нь төсөв. Төрийн албан хаагчдынхаа тоог цөөлөх хэрэгтэй. Энэ эрх мэдэлтнүүд чинь их байх тусам тэр авлигын чинь эх үүсвэр өөрөө суурь нь тэндээ. Тэгэхээр ахиад эндээ төрийн албаныхаа тоог яаж цомхотгох вэ гэдэг энэ юмнуудаа.

**Б.Энхбаяр:** Нямбаатар сайд тодруулгад хариулъя.

**Х.Нямбаатар:** Бид нарын бас олон улсын байгууллагуудад энэ Трансперенси интернэйшнал ч тэр ФАТФ дээр ч тэр бид нарын бас нэг оноо алдуулаад байгаа зүйл бол төр хувийн хэвшлийн түншилэл. Төр өөрөө бүх чиг үүргээ өөрөө хэрэгжүүлэх шаардлагагүй аутсорсинг хийх замаар төрийн чиг үүргүүдээ шилжүүлэх энэ чиглэл дээр бид нар хөшүүн хойрго байгаа.



Хоёрдугаарт Энхбаяр даргын ахалсан ажиллаж байгаа манай яаманд боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай дээр нэг том чухал санаа оруулж ирсэн нь төр 5, 5 жилээр ямар бизнес хийхээ урьдчилж Их Хурлын тогтоолоор батална. Тэр батлаагүй чиг үүргээрээ чиглэлээрээ бизнес хийхгүй байна.

Хийсэн бизнес нь маш ойлгомжтой бөгөөд гүйцэтгэх удирдлагууд нь нөгөө ой си ти-гийн зарчмаар тэр бизнесийг удирдана гэдэг энэ зарчим орж ирж байгаа юм. Тэгээд дээр нь энэ хэдүүлээ энэ манай.

**Б.Энхбаяр:** Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяа:** Энэ авлигын эсрэг энэ хөтөлбөр өнөөдөр Улсын Их Хурлаар бид хэлэлцэж байгаа. Авлигатай тэмцэх, авлигыг бууруулах асуудал өнөөдөр Монголын нийгмийн хүрээнд хамгийн их анхаарал татсан асуудал болж 30 жилийн хугацаанд үүссэн авлигал төрийн өмч хөрөнгийг хулгайлдаг, төрийн өмч хөрөнгөөр бизнес хийдэг энэ эрсдэлийг яаж арилгах вэ гэдэг талаар сүүлийн нэг жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газар, авлигатай тэмцэх байгууллагууд бас тодорхой үр дүнтэй ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгэхдээ авлигатай тэмцэж байна гээд аливаа асуудлыг олон нийтийн сүлжээгээр тараагаад тэр нь ямар үр дүнд хүрч байгаа юм, ямархуу шийдэл гарч байгаа юм гэдэг ийм асуудал бол тодорхой бус байна. Тодорхой бус байна.

Тэр хүний эрхийг хамгаалагчийн тухай хууль гэдэг асуудал түүнчлэн прокурорын зөвшөөрлөөр мөрдөн шалгах ажиллагааны асуудлуудыг олон нийтэд мэдээлнэ гэдэг энэ асуудал чинь өнөөдөр хэр нийцтэй байгаа вэ гэдэг дээр бас энэ мөрдөх байгууллага Монгол Улсын Засгийн газрын хариуцлага. Хүмүүс энд бас дүгнэлт хийх ёстой гэж бодож байгаа. 5 ш ажиллагаа гээд л одоо Засгийн

газраас олон зүйл олон ийм дэс дараатай арга хэмжээнүүдийг авсан. Шүгэл үлээсэн.

Тэгээд энэ нэг асуудал чинь ерөөсөө ингээд нэг хэвлэл мэдээллийн хүрээнд олон нийтийн анхаарлын төвүүд асуудлууд орж ирээд тэрний үр дүн жинхэнэ нөгөө нийтийн алба, Ашиг сонирхлын тухай хууль, бусад хуулиудын чинь хүрээнд энэ асуудал ер нь тодорхой бус байгаа л гэдэг ийм бас нэг ойлголттой байгаа.

Харин сүүлийн үед Засгийн газраас энэ хууль эрх зүйн орчныг сайжруулах эрх зүйн орчноор дамжуулж авлигатай тэмцэх хөрс суурийг бий болгох талаар бас тодорхой үр дүнд хүргэж хүрч байгаа гэж ойлгож байгаа. Мөн түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас Монголын төрөөс авлигын эсрэг олон улсын өмнө хүлээсэн үүрэг мөнгө угаах, терроризмтой тэмцэх талаар бас тодорхой шийдлийн асуудлуудыг яаж ямар байгууллагуудтай холбоо тогтоож ямар үр дүнд хүрч байна аа? Энэ шүгэл, шүүр гээд баахан олон гадаадад оргон зайлсан гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийг Монголд авч ирнэ гээд ингээд яриад байгаа. Хэчнээн хүн өнөөдөр авч ирчхээд байна. Ямар үр дүнд хүрчхээд байна.

Тэгээд өнөөдөр ингээд шүүх, прокурор, шүүх эрх мэдлийн асуудал дээр л юм гацаад байгаа тухай мэдээлэл бид өгөөд байдаг. Гэтэл мөрдөх байгууллага, авлигатай тэмцэх байгууллага ялангуяа энэ хүний эрхийг хамгаалах асуудал дээр бол бас бас цаашидаа энэ мөрдөн шалгалгүй яах вэ энэ дээр бас дүгнэлт хийж ажиллах ёстой шүү гэдэг ийм нэг саналыг хэлье. Тэгээд тэр асуудлыг Нямбаатар сайдаас асууя.

**Б.Энхбаяр:** Нямбаатар сайд хариулъя.

**Х.Нямбаатар:** Нийтдээ 127 хүнийг бид нар энэ мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зайлсан байж

болзошгүй 127 хүнийг гадаад улсаас авчиръя гэдэг ийм ажлын хэсэг дээрээ судалгаа гаргасан. Энийг мэдээж хэрэг прокурорын байгууллагын зөвшөөрсөн хүрээнд олон нийтэд танилцуулсан. Үүний 25 хүн нь АТГ-ын харьяалан шалгаж байсан авлига албан тушаалын гэмт хэрэгт шалгагдаж байхдаа оргон зайлсан гэдэг ийм мэдээллийг авсан. Үлдсэн хүмүүсийн тухайд бол ихэвчлэн цагдаагийн байгууллагын мөрдөн шалгах үйл ажиллагаанаас оргон зайлсан гэсэн ийм статистик тоотой байгаа. Бид нарын яг албадан болон өөрсдөө сайн дураараа авчирсан хүний тоо өнгөрсөн 7 хоногт 15 хүн болж байсан. Энэ 7 хоногт бид нар бас энэ тусгай үүргийн нислэгээр 10 гаруй хүнийг авчрах энэ бэлтгэл ажил үндсэндээ хийгдээд байгаа. Яг одоо хаана байгаа нь тогтоогдоогүй нэг 25, 26 хүн байна. Бусад хүмүүсийн тухайд хаана байгаа нь үндсэндээ тогтоогдож байгаа гэж ойлгож болно.

Хоёрдугаарт нэг юмыг хэлэхэд зүгээр анх удаагаа ер нь манай энэ мөрдөх байгууллагууд ингэж хамтарч гаднаас хүмүүсээ авчрах ийм ажил операц зохион байгуулж байгаа юм байна лээ. Өмнө нь 2 удаа авчрахдаа хууль бусаар авчирсан тохиолдол гарсан. Үүнээс болж бас бид нар асуудал үүссэн гэдгийг та бүхэн мэдэж байгаа.

Тэгэхээр цаашид бид нар энэ ажлыг эрчимжүүлнэ гэдгээ хэлье.

**Б.Энхбаяр:** Раднаасэд гишүүн асуултаа асууя.

**Ш.Раднаасэд:** Би уул нь энэ даргаас нь асууя гэсэн дарга нь алга байна шүү дээ АТГ-ын. Чуулган дээр л асууя.

Хоёрдугаарт энэ бичлэг АТГ дээр бичсэн хөтөлбөр биз дээ? Хууль зүйн яам дээр бичсэн юм уу? Танай яам уу? Энэ 10 дугаар зорилго 10 гээд энэ Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын дээрх авлигыг гээд тусгайлан онцгойлчихсон юм байх

юм. Би бодохдоо энэ чинь хамгийн их авлигад өртдөг газруудаа энд бичих гээд байна гэж ойлгоод байна шүү дээ. Тэгснээ гамигаас хамгаалах үеийн санхүүжилт хандив гээд дээд талд нь болохоор Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудад хоёрхон байгууллагыг энэ дээр онцолчихсон байх юм. Бид нар өөр авлигатай холбоотой бусад энэ яг өнөөгийн цаг үетэй холбоотой юмыг нь тэр дарга нь ирвэл би байнга чуулган дээр асууя.

**Б.Энхбаяр:** Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Тогтоолын төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Алга байна.

Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Сүхбаатар гишүүн үг хэлье.

**Ж.Сүхбаатар:** Тэгэхээр би бол Их Хурлын гишүүнийхээ хувиар бол хэлэх гэж байгаа юм. Манай Улсын Их Хурал дахь бас авлигын эсрэг бүлэг гээд ингээд хэдэн гишүүн байдаг. Бүгд чиглэл чиглэлдээ их идэвхтэй ажиллаж байгаа хүмүүс байгаа. Өнөөдөр Засгийн газрын ингээд хөтөлбөр орж ирж байна.

Тэгээд би энэн дээр бол яах вэ Засгийн газрын хурал дээр ч тэр тодорхой хэмжээнд байр сууриа нэг их хэлээгүй. Яагаад гэвэл энд тусгагдаж байгаа асуудлууд бид нар маш олон асуудлуудыг тусгачихсан байгаа. Тэгэхээр одоо хамгийн гол юм бол юундаа байна вэ гэхээр гишүүд ч гэсэн анхаарах юм бол авлигын индексийг бууруулах асуудал дээр манай зүйн сайд бол ингээд Трансперенси интернэйшнлийн ингээд үзүүлэлтүүдийг яагаад зөндөө ажиллаад тэгээд энэ дээр бас бүтэц зохион байгуулалтын хувьд анхаарах асуудлууд байна гээд байгаа юм. Бид их яриад байдаг нөгөө индекс маань бас хойшлоод байгаа юмнууд байгаа.

Тэгэхээр энэ хөтөлбөрийг батлах гээд явж байх үед бид нарын шийдэх

ёстой асуудлууд дотроос хамгийн чухал юм нь улс төрийн намын асуудал байгаа шүү. Энэндээ хэдүүлээ идэвхтэй оролцоод энэ хөтөлбөртэйгөө уялдуулаад эхний шийдэх асуудал энэ Улс төрийн намын тухай байгаа. Энэ хөтөлбөр орж ирэхээс өмнө бид нар сонгуулийн хуулиа шийдчихсэн. Зарим асуудлууд нь бол сонгуулийн хуульд сууцхсан юмнууд бол бий. Гэхдээ араас нь дахиад бас анхаарах юмнууд байна лээ энд байгаа.

Тэгэхээр энэ Улсын Их Хурал бол энэ авлигатай тэмцэх хөтөлбөр дээр бол бүүр нэлээн онцгой ач холбогдол өгөөд тэгээд энэ түрүүн Хууль зүйн сайд бол намын бүлэг Засгийн газар дээр танилцуулаад байсан асуудлууд байгаа. Тэрийг бол жишээлбэл Нямбаатар сайд бол Улсын Их Хурал дээр ч гэсэн энэ Байнгын хорооноос гадна АН-ын бүлэг гэдэг юм уу бусад улсуудаа ч гэсэн танилцуулмаар юм байна лээ. Энэ манай үзүүлэлтүүдийн ихэнх нь бол эдийн засгийн чиглэлтэй бас үзүүлэлтүүд их чухал юм байна лээ. Ганцхан Хууль зүйн яам нэг шударга ёсны байдал гээд хариуцдаг биш. Энэ дотор яригдаж байгаа асуудал бол Эдийн засаг хөгжлийн яамтай холбоотой, Сангийн яамтай холбоотой гээд байгаа.

Тэгэхээр бид нарын одоо хамгийн гол юм бол энэ хөрөнгө оруулалтын бодлогын асуудлууд өмчийн асуудлууд байгаа. Ирэх намар бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай гэж байгаа.

Тэгэхээр манай энэ удаагийн Их Хурал бол хамгийн гол шийдэх юм бол энэ төрийн болон орон нутгийн өмчийн асуудал байгаа шүү. Тэгээд гишүүд бол энэ чиглэл болгон дээр идэвхтэй байгаа. Энэ Хууль зүйн байнгын хорооны гишүүн болгон энэ авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр бусад чиглэл дээр бол бас идэвхтэй оролцоосой. Тэгээд энэ удаагийн Их Хурал ч гэсэн хэчнээн хэл амтай байгаа ч гэсэн хамгийн энэ асуудлууд дээр бодитой бөгөөд зүйн хувьд тэмцсэн ийм

Улсын Их Хурал болж ажиллах болно гэдэг ийм итгэл үнэмшилтэй байгаа. Энийгээ бас хэлье.

Тэгээд тэр юун дээр бол асуудал байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль шүүх байгуулах тухай хуулиуд гээд ингээд ар араасаа цувраад орно зөрчлийн хууль бас байж байгаа. Тэгэхээр энэ асуудлууд дээр бид ингээд цогцоор нь манай Байнгын хороо, Байнгын хорооны дарга бол анхаарал хандуулж бидний хийх ажлын том амжилт бол энэнтэй бас их нэлээн уялдаатай гэж энд бас би протоколд бас тэмдэглүүлж байгаа.

**Б.Энхбаяр:** Би нэг товч үг хэлчихье. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн тогтоолын төсөлд суусан асуудлаар ирэх 7 хоногт эхний хэлэлцүүлгийг нь хийх бодолтой байгаа. Энэ Ажлын хэсгийнхээ дэд хэсгийнхээ бүрэлдэхүүнээр ажиллачихвал их зүгээр байх гэж би бодож байгаа. Бас юмаа мэдэж байгаа хийсэн. Гишүүд төсөл хэлэлцэх эсэхийг нь Байнгын хороо дэмжээд чуулганаар мэдээж дэмжинэ. Ирэх 7 хоногт хийх учраас тодорхой хөтөлбөр дээр санал байвал Байнгын хороо бас ирүүлмээр байна тодорхой санал байвал. Миний хувьд бас энэ хөтөлбөр бол бас бусад өмнө баталсан бодлогын реформдоо бас нийцэх ёстой гэсэн хүрээнд жишээлбэл энэ авлигын гэмт хэргийг давж заалдах шатны шүүх анхан шатын журмаар шийдвэрлэх гэдгийг бол миний хувьд энэ бодлого нөгөө шүүхийн хуулийн концепцтой нийцэхгүй байна гэж үзэж байгаа.

Бид нар бол Шүүхийн хуулийн концепц сая ердөө 7 хоногийн өмнө Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн дагуу холбогдох өөрчлөлтийг хийж байгаа энэ сүүлийн 2 жил хэрэгжүүлж байгаа концепц бол Улсын дээд шүүх ер нь энэ хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хүрээндээ л гол чиглэх ёстой. Тэрнээс өөрөө хэрэг маргааныг таслан шийдвэрлэх чиглэл рүү оруулж бол

болохгүй гэдэг ийм концепцын шинэчлэл хийгээд явж байгаа.

Хэрвээ давж заалдах шатны шүүх анхан шатын журмаар шийдээд эхэлбэл Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүх болчихно гэсэн үг.

Тэгэхээр бид энэ нөгөө Шүүхийн хуулийнхаа концепцтой нийцэхээ больчихоод байгаа.

Тийм учраас энийг бас эхний хэлэлцүүлгийн шатанд анхаарч энэ Шүүхийнхээ хуулийн гол концепц шүүхийн реформынхоо бас гол концепцыг бид бас ингээд эргээд алдагдуулаад байж би болохгүй гэж бодож байгаа. Ер нь бол энэ 6.4.3-д байгаа юм шүү. Авлигын хэргийг давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэх гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ маань өөрөө Дээд шүүхийг буцаагаад хэрэг шийддэг шүүх болгох гээд байгаа юм. Энийг одоо бас ажлын хэсгийн явцад анхаараарай гэдгийг хэлье.

Гишүүд үг хэлж дууслаа. Бас санал хураалт явуулна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

100 хувийн саналаар дэмжигдлээ. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх талаарх хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Танилцуулгыг Цогтбаатар гишүүн танилцуулчих уу? Санал дүгнэлтийг Цогтбаатар гишүүн танилцуулъя.

Дараагийн асуудалдаа оръё.  
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 04 дүгээр дүгнэлт.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82.20.1-д Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь эсхүл зарим хэсгийг нь хүлээн зөвшөөрөх эс зөвшөөрөх асуудлаар санал дүгнэлт гаргах гэж заасан байгаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн 2023 оны 4 дүгээр дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар товч танилцуулга хийнэ ээ.

Тэмүүлэн гишүүний микрофоныг өгье.

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүдэд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 4 дүгээр дүгнэлттэй холбоотой бас товчхон мэдээллийг та бүхэнд өгье.

Монгол Улсын иргэн Цолмонбат, Энхтүвшин, Эрдэнэцэцэг нар Үндсэн хуулийн цэцэд бол энэ Онцгой албан татварын 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10, Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 4, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэсэн маргааныг бол бас гаргасан байсан. Ингээд Цэцийн хуралдаан 2023 оны 6 сарын 16-нд хуралдсан. Энэ хуралдаан дээр Үндсэн хуулийн цэцийн гишүүн Туулхүү даргалж, Цэцийн гишүүн Солонгоо, Баясгалан, Эрдэнэбулган нар гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр бол хуралдсан.



Үндсэн хуулийн цэцэд Төсвийн байнгын хорооноос итгэмжилсэн төлөөлөгчийн хувиар бол бас бид нар энэ тайлбар мэдээлэл бол хүргүүлсэн.

Нэг талдаа энэ мэдээлэл гаргагч нартай холбогдуулж Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчөөгүй гэсэн тайлбар мэдээллүүдийг бол өгсөн. Энэ дотроо бол яах вэ гомдол гаргасан цэцэд хандсан иргэдийн зүгээс бол үндэсний үйлдвэрлэл хөгжих боломжийг хааж байна, импортлогчид давуу байдлыг бий болгож байна. Татварын дарамтад оруулах, зах зээлийн үнэ өсгөх судалгаа нотолгоогүй ийм зүйлүүд бол байна гэсэн.

Энэ үндсээр бол хандсан байсан. Ингээд бид нарын хувьд бол тодорхой энэ асуудлыг бол тайлбар тавихдаа бол нэг талдаа энэ онцгой албан татвар гэдэг нь бол бохирдуулагч зүйлд тавьдаг татвар байгаа. Тэр дундаа хүн байгальд сөрөг нөлөөтэй аливаа бараа үйлдвэрлэл үйлчилгээнд ноогдуулдаг татвар. Тэгээд энэ үндсэн дээрээ бол Улсын Их Хурал өөрийнхөө бүрэн эрхийн хүрээнд энэ татварыг бол ноогдуулсан.

Өнөөдрийн энэ стандарт бус шатахууныг үйлдвэрлэж байгаа энэ асуудлыг бол бид нар бас нэг талдаа энэ өөрөө байгаль орчинд болоод хүрээлэн буй орчинд тэр дундаа хүний эрүүл мэндэд бол сөрөг хорт нөлөөтэй эдийн засгийн болон экологийн сөрөг нөлөөтэй учраас энийг бол хэрэглээг нь татварын бодлогоор хязгаарлах нь зүйтэй. Төрөөс иргэдийнхээ эрүүл аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бодлого гаргах үүрэгтэй. Энэ үндсэн дээрээ бид нар бол энэ асуудлыг Улсын Их Хурал өөрийнхөө бүрэн эрхийнхээ хүрээнд бол шийдвэрлэсэн гэдэг байдлаар бол энэ тайлбар мэдээллийг хүргүүлсэн байгаа.

Үндсэн хуулийн цэцээс гаргасан гол үндэслэл дээрээ бол Монгол Улсын Их Хурал газрын тосны энэ үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосинд энэ онцгой татвар ноогдуулахаар байгаа нь бол

хууль тогтоогч холбогдох тооцоо судалгаанд үндэслэхийн зэрэгцээ төрийн бусад бодлоготой уялдуулах, хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой нийцүүлэх ёстой.

Гэтэл энэ Онцгой албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг холбогдох судалгаа бүрдүүлбэрийн хамт өргөн мэдүүлсэн байх боловч дүгнэлт судалгаа нь иж бүрэн бус бодит байдалд нийцээгүй ээ.

Тэгэхээр энэ хуулиар зохицуулах харилцаанд оролцогчид бол эрх зүйн байдал болоод улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх асуудлыг тусгаагүй гэдэг энэ үндэслэлээр бол хууль дээдлэх зарчмыг бол алдагдуулсан байна гэж энэ дүгнэлтийг гаргасан байгаад байгаа.

Тэр дундаа одоо Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд тусгагдсан байгаа. Энэ татварын дарамт аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны хүндрэл үүсгэж болзошгүй байгааг анхаарах ёстой гэсэн санал, дүгнэлтийг бол бас анхаарч үзээгүй байна тэгээд иймд бол Онцгой албан татварын тухай хуулийн маргаан бүхий заалтууд нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн холбогдох заалтыг тус тус зөрчсөн гэх үндэслэлтэй гэсэн энэ дүгнэлтийг бол Үндсэн хуулийн цэцээс бол гаргасан байгаад байгаа.

Тэр дундаа 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тэгш байдал хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. Мөн төр нь Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэснийг бол тус тус зөрчсөн байна гэсэн энэ зүйлийг бол тавьсан байгаад байгаа юм.

Харин онцгой албан татварын 4.1.5, 4 дүгээр зүйлийн 4.1.5, 5 дугаар зүйлийн 5.1.6, 6 дугаар зүйлийн 6.1.10 дахь

заалтууд нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн шударга ёс нь төрийн үйлчилгээний үндсэн зарчим мөн. Мөн 19 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн төрөөс хүний эрх эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гэснийг бол зөрчөөгүй гэсэн дүгнэлтийг бол гаргасан байгаа юм.

Тэгэхээр Үндсэн хуулийн цэцийн 1 дүгээр дүгнэлтээр бол зөрчсөн, 2 дахь дүгнэлтээр бол зөрчөөгүй, 3 дахь энэ заалтаараа бол тодорхой энэ онцгой албан татварын 4.1.5, 5.1.6, 6.1.10 дахь заалтуудыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх үйл ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрөөс түдгэлзүүлсүгэй гэсэн энэ шийдвэрийг бол гаргасан байгаа гэдгийг та бүхэнд бас мэдээлэл болгож хэлэх байна.

**Б.Энхбаяр:** Тэмүүлэн гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Мөнх-Оргил гишүүнээр, Баттөмөр гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

**Б.Пүрэвдорж:** Энэ хуулийг 2021 оны 7 сарын 4-ний өдөр батлуулсан. Тэгээд үнэхээр ард түмэнд маш хорттой, эдийн засагт хорттой, үр хүүхдүүдэд хорттой л ийм бизнес байгаа юм. Өөрөөр хэлбэл томоохон нефтийн баазын том торхнууд байдаг. Тэр торхны 75 хувьд нь дизелийн түлш хийчихдэг. Тэгээд үлдсэн 25 хувьд нь керосин, нафта зэрэг бүтээгдэхүүнийг авчирч хольдог. Тэгээд доор нь сэнс байдаг. Тэр сэнсээр эргүүлдэг. Тэгээд хуйлруулаад. Тэгээд хуйлруулж эргүүлчхээд тэгээд тэр нь юу байдаг юм? Нэг суманд очоод буулаа гэхэд тэр сумын колонк ачаад буулгаж байгаа юм. Тэгээд бүх сумын колонк нь

доороо сэнс байх юм биш тэр чинь хүнд металл нь доошоо унаад, хөнгөн металл нь дээшээ гарчихдаг юм. Тэгээд ард түмний машиныг эвддэг юм. Жил болгон цахилгаан карбератор тэгээд л тэр дизель аппаратур энэ тэрээ бүгдийг нь сольдог байхгүй юу даа.

Тэгээд дээрээс нь манай төрийн өмчийн автобусны компаниуд ер нь Улаанбаатар хотын автобусны компаниуд хамгийн хямдхан шатахуун хэрэглэдэг юм. Тэрийг хэрэглэсэн автобуснууд хар утаа хаядаг юм. Тэр хар утаа нь та нар санаж байгаа бол хоёрхон жилийн өмнө энэ жил алга болчихсон л доо. Сүүлийн 2 жил алга болчихсон. Тэр замын хажуу талын цахилгааны шонгийн доод тал нь хав хар болчихсон байдаг. Тэр чинь яаж байна гэхээр тэр хүнд металл нь тэнд 50 метрээс доош дэгдээд тэнд нь ингээд хар болчихсон. Бид нар нөгөө метрээс дээш метр хагасаас дээш болохоор тэрүүгээр чинь амьсгалдаггүй. Метрээс доош тэр бузартай утааг үнэрлэсэн тэр хүүхдүүд, бидний алдрай үрсүүд бүгдээрээ өвчин зовлонтой, ханиад томуутай бүх юмны утга учир нь энэ болж байгаа юм. Энэ ард түмний машин тэргийг эвдчихээд энэ чинь 2020 онд 230 мянган тонн керосин нафта орж ирсэн шүү дээ. Тэр Монголд тийм хэрэгцээ огт байхгүй. Үсрээд л 100 тонны л хэрэгцээ байгаа.

Тэгээд тэрнийгээ ингээж хольчихоод нийтдээ 60 гаруй тэрбум төгрөгийн татварын ашиг олдог. Дээрээс нь дахиад тэр дизель түлш нь 600 доллар орж ирлээ гэхэд нөгөө керосин 400 доллар орж ирдэг. Тэгээд үнийн зөрөөнөөс ашиг олдог. Ингээд бараг зуугаад тэрбум төгрөг монголчуудын машин тэргийг эвдчихээд тэгээд татвараас зайлсхийж байгаа шүү дээ тэр чинь. Монгол Улс татвартай болъё гээд байна шүү дээ. Гэтэл ийм зүйлийг хийдэг энэ компанийн эрх ашигт Үндсэн хуулийн цэц увайгүйгээр оролцож ямар бузартай юм бэ. Ингээж болохгүй шүү дээ. Энийг Их Хурлын гишүүд маш их зориг гаргаж энийг баталсан. Тэгээд

ингээд энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авах юм бол үнэхээр увайгүй зүйл болно. Тэгээд энийг кноп дараад дэмжих юм бол ч мэдэхгүй би дэмжсэн хүмүүсийг нэрийг нь сайн тавина. Тэгж байгаад ард түмнээрээ сайхан эсэргүүцүүлнэ. Ямар дүн тавьж өгөхийг нь та нарт нэг харуулж өгнө гэдгийг хэлье. Энэ ёстой увайгүй зүйл шүү.

**Б.Энхбаяр:** Энэ хууль зүйн үндэслэл ярьдаг газар болохоос биш энэ чинь тэгж асуулт биш байна. Үг хэлчихлээ тийм ээ? Одоо бол асуулт явж байгаа юм. Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

**Ж.Сүхбаатар:** Би бол энэ талаар мэдлэггүй хүн л дээ. Тэгээд өмнө нь бол яг тэр саналаа өгөхөд бол энэ Пүрэвдорж маань хуурамч шатахуун ёстой баларлаа гээд байсан. Тэгээд нөгөө чуулганы хуралдааны хажууд байж байхдаа би тэгээд дэмжиж саналаа өгсөн юм. Тэгээд сүүлд нь энэ яг хуурамч шатахуун гээд яг юу хэлээд байгаа юм бол гэдэг асуудал байгаа. Тэгээд энэ дээр манай Тэмүүлэн бол ийм заалт байсан. Стандарт бус шатахуун байна. Хямд зардлаар нийлүүлээд байна. Тэгээд тээврийн хэрэгсэл эвдээд байна гэж. Энэ чинь нууцаар Монгол Улсын хуулиар хориглочихсон юм уу? Стандарт бус шатахуун гэдэг ойлголт нь яг юу хэлдэг юм? Хуурамч шатахуун гэж ойлголт байна уу? Эсвэл манай иргэдийг хууран мэхлээд тэд нар мэдэхгүйгээсээ аж ахуйн нэгж байгууллагууд тийм хямд шатахуун авч хэрэглээд байдаг юм уу? Өөрсдөө тэгээд хохироод байдаг юм уу? Нэг ийм юм явагдаад байгаа байхгүй юу. Хуурамч шатахуун гэхээр чинь хэн ч гэсэн хуурамч юманд дургүй гээд л үзнэ. Гэтэл хуурамч юм тэр чинь хуулиар хориотой байх ёстой шүү дээ. Хэрэглээ байгаа бол тэр хэрэглэгчийг зальдаад, хууран мэхлээд байгаа бол хэрэглэгчид мэдээлэл өгөхгүй байгаа тийм асуудлууд манайд Монгол Улсын хууль тогтоомжоор бид нарт ийм юм үүсгээд байгаа юм уу? Эсвэл тэр

улсууд мэдэхгүйгээсээ болж авч үнэхээр хэрэглээд байгаа юм байгаа юм уу?

Тэгээд энэ асуудал дээр бол ялангуяа Пүрэвдорж гишүүн маш их тийм ярьж байгаа учраас сонирхол татаж байсан учраас би энэ асуудлууд дээр энэ цаад учир шалтгаан нь юу байгаад байгаа юм? Үнэхээр эсвэл энэ бизнесийн орчинд өрсөлдөөн яваад байгаа юм уу улс төрийн сонирхол яваад байгаа юм уу? Эсвэл тодорхой тэр нэг ашиг сонирхлоор ингээд хандаад байгаа юм уу? Ийм юмнууд бол сүүлийн үед их хүчтэй яригдаж байгаа байхгүй юу. Бид нарын хувьд бол энэ асуудал дээр чинь ингээд сая Үндсэн хуулийн цэц бол энэ дээр ирчихсэн байна шүү дээ. Энэ асуудал дээр судалгаа, тооцоо танилцуулаагүй, хуурамч шатахуун гэж эргээж хаихирсан. Тэгээд энийг дэмждэг дэмждэггүйгээр ард түмнээ хуваана. Шударга шударгаа тогтооно гээд ингээд яриад явчихсан байхгүй юу. Өмнө нь бол Пүүжээ гишүүн бид нар чинь дэмжсэн шүү дээ.

Тэгэхдээ ийм асуудлууд дээр яг одоо ингэхээр үндэслэлээ хэлэх ёстой байхгүй юу. Тэрнээс биш заналхийлж байгаа ч юм шиг урьдчилаад л, ер нь удаа дараа нэг ийм хууль хийхдээ нэг тийм, чамайг тэгнэ, өлгөнө шонд өлгөнө. Нийгмийн даатгалын хууль, тэгвэл ингэнэ гэж. Энэ чинь Улсын Их Хурлын гишүүний хувьд бол байж болохгүй зүйл байхгүй юу. Тэр чинь нэг бус удаа үйлчилж байна шүү дээ. Урьдчилаад ямар шийдвэр гаргах юм билээ. Одоо бараг ингээд сонсонгуут уур хүрч байна шүү дээ энэ чинь хаашаа юм бэ? Энэ чинь Пүрэвдоржийн үгээр зөндөө л олон хууль дээр чинь дэмжиж л байгаа шүү дээ.

**Б.Энхбаяр:** Тэмүүлэн гишүүн хариулъя.

Мөнх-Оргил гишүүн асуултаа асууя.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ Татварын хуульд оруулсан нэмэлт,

өөрчлөлтийг дэмжээд л явуулсан л даа. Тэгээд нэг ийм асуулт байгаад байгаа юм Тэмүүлэн гишүүн ээ.

Яах вэ энэ оруулах нь зөв нэг дүгээрт тэр бүтээгдэхүүний аюулгүй байдлын асуудал байна.

Хоёрдугаарт хамгийн гол нь энэ чинь зарим нь эцсийн бүтээгдэхүүн дизель гэж нэртэй оруулж ирээд татвараа төлөөд байдаг, яг адилхан бүтээгдэхүүн гаргаад тэгсэн мөртөө тэрнийхээ татварыг нь төлөхгүй байгаа нь л жинхэнэ ялгавартай нөхцөл бид нар бий болгоод байгаа байхгүй юу. Тэгээд адилхан л оруулж ирж байгаа бол тэр дизель байна уу татвараа төл. Ирээд дизель хийгээд татвараас бултаад байгаа бол татвараа төлөөд л дизелиэ борлуул. Тэр чанарын шаардлага хангахгүй байгаа бол тэр бүх өөр энийг нь хориглодог юм уу, яадаг юм. Тэгэхээр энэ дээр яг дүгнэлтийг нь уншихлаар байна шүү дээ. Цэц их нюанстай дүгнэлт хийсэн байгаа байхгүй юу. Цэц бол ерөөсөө энийг бус гэж хэлээгүй. Эсвэл одоо Улсын Их Хурал болохгүй хууль гаргачихлаа гэж хэлээгүй.

Цэц юу гэж хэлсэн байна вэ гэхээр Хууль, тогтоомжийн тухай хуульд заасан процесс хийгдээгүй байна. Засгийн газрын санал, дүгнэлт авагдаагүй байна. Хууль тогтоомжид заасан үндэслэл, судалгаа хийгдээгүй байна. Энэ чинь өөрөө хууль дээдлэх зарчмыг зөрчсөн байна гэсэн дүгнэлт хийсэн байгаа байхгүй юу. Тэрнээс биш Пүрэвдоржийг буруу хууль санаачлаад, Улсын Их Хурал буруу хууль баталчихлаа гэж. Тэгэхээр хурал дээр нь сууж байсан Тэмүүлэн гишүүнээ Цэц зарим тохиолдолд яг нөгөө хэлэлцүүлэг хийгдэж байхад Цэцийн гишүүд саналаа хэлдэг байхгүй юу. Үгүй энийгээ засаад оруулаад ирэх юм бол асуудалгүй гэж. Тийм ээ процессын алдаатай байсан байна. Процессын алдаагаа засаад ирэх юм бол асуудал алга гэж жишээ нь хэлдэг байдаг юм.

Тийм санал онол хэлж байна уу, эсвэл тийм санал хэлэхгүйгээр зүгээр л энэ хууль зөрчсөн байна гэсэн дүгнэлтээ хэлээд дуусчихсан уу? Энэ чинь нөгөө процесс яриад байгаа байхгүй юу Цэц чинь яг дүгнэлтийг нь унших юм бол. Тэрнээс биш Их Хурал бол татварын хууль өөрчлөх ёсгүй гэж хэлээгүй л байгаа байхгүй юу. Энэ нюансыг нь гаргаадаа даа. Бид нар чинь энэ нюансыг л гаргах гэж энд сууж байгаа юм чинь. Тийм юм хэлсэн бол нэг асуудал арай өөр болно. Тийм юм хэлээгүй зүгээр хууль зөрчсөн байна.

Хоёр хууль хоорондоо зөрчилдсөн байна эсвэл бизнес эрхлэгч нарт өөр өөр нөхцөл олгосон байна энэ тэр гэх юм бол тэр чинь хууль тогтоогч бид нарын эрхийн асуудал шүү дээ. Хэнд нь давуу байдал олгох вэ хэнд нь давуу байдал олгохгүй байх вэ гэдэг чинь тогтоогч шийднэ. Татварт ноогдуулах уу, ноогдуулахгүй юу гэдгийг хууль тогтоох шийдвэрлэнэ. Тэр байтугай 2 хуулийн хооронд зөрчил гарах юм бол тэр Цэцийн асуудал биш байгаа байхгүй юу.

Тэр бол хууль дээдлэх зарчим зөрчсөн асуудал биш. Тэр бол Улсын Их Хурал 2 хуулийн хооронд зөрчил гарсныг засах бололцоо нь байж л байгаа байхгүй юу. Энэ асуултад хариулт авъя.

**Б.Энхбаяр:** Тэмүүлэн гишүүн хариулъя.

**Г.Тэмүүлэн:** Мөнх-Оргил гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр яг л Цэцийн дүгнэлт бол яг л таны бас хэлж байгаа шиг яг энэ Онцгой албан татварын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт бол яг энэ холбогдох судалгаа болоод бүрдүүлбэрийн хамт бас өргөн мэдүүлэх ёстой байсан. Дүгнэлт судалгаа нь өөрөө иж бүрэн бус бодит байдалд нийцээгүй.

Дээр нь юу гэдэг юм энэ харилцаанд оролцогч талууд эрх зүйн



байдал болоод улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх асуудлыг тусгаагүй гэдэг асуудлаар бол нэг талдаа үндэслэж энэ хууль дээдлэх зарчмыг бол алдагдуулсан гэж гарсан байгаад байгаа юм. Үндсэн хуулийн цэцийн энэ хуралдаан дээр бол яг хэрэв та бүхэн процессын алдаа гаргасан бол энэ процессынхоо алдааг засаж залруулаад орж ирэхэд энийг магадгүй юу гэдэг юм бид нар цэц бас эргэж харж үзнэ гэсэн байдлаар бол ямар нэг тийм зүйл хэлээгүй. Ерөнхийдөө Цэцийнхээ дүгнэлтийг танилцуулаад ингээд хуралдуулсан байгаа.

**Б.Энхбаяр:** Раднаасэд гишүүн асуултаа асууя.

**Ш.Раднаасэд:** Юу ч болчхов би сайн ойлгосонгүй. Сая Мөнх-Оргил гишүүн нэг халти дурдаад өнгөрчихлөө. Ер нь энэ татвартай байх уу татваргүй байх уу? Татвар байвал хэдэн хувь байх вэ хэдэн төгрөг байх вэ гэдэг чинь энэ Засгийн газрын бодлого биш үү? Цэцийн асуудал мөн юм уу? Яг энэн дээр ингэж цэц орж шийдвэр гаргах ёстой юу? Удахгүй ААНОАТ 10 хувь байгаа чинь бага байна 15 хувь болго ч гэдэг юм уу эс үгүй бол энэ хөдөө аж ахуйн чиглэлийн тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлж байгаа чинь буруу байна гэдэг ийм юм руу л бид нар явах гэж байна шүү дээ. Энийг очиж ярьсан уу?

Нэгдүгээрт энэ улс төрийн шийдэл байхгүй юу. Улс төрийн шийдвэр энэнийхээ эсрэг цөөнх болсон ч гэсэн гишүүд гарч ирээд Их Хурлынхаа эсрэг өөрсдийнхөө гаргасан хуулийн эсрэг юм ярьдаггүй биз дээ. Олонхоороо дарчихсан юман дээр. Тэгээд тэнд 9 хүн сууж байгаад асуудал дахиад шийдчихсэн шүүхийн тухай дээр Үндсэн хууль зөрчсөн, зөрчөөгүй гэхээд гэхдээ та нар энэ хуулийн зүйл заалтуудыг чинь түдгэлзүүлээ шүү гээд. Ингээд энэ чинь арай хэтэрч байх шиг байна.

Нэгдүгээрт энэ татварын асуудал дээр Их Хурал ч оролцох эрхгүй шүү дээ.

Дангаараа хувь гишүүд хууль санаачлаад явах ч зүйн боломж байхгүй биз дээ Үндсэн хуулиар. Энэ чинь 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр зөвхөн Засгийн газар энийг хийнэ гээд. Үгүй би тэрийг чинь яриагүй л дээ. Одоо энэ хууль чинь ингээд явлаа гэхэд дэмжигдлээ гэхэд Байнгын хороо ч энийг засах эрхгүй байхгүй юу. Тийм Үндсэн хуулийн заалт бид нарт байхгүй. Цэцийн дүгнэлтийг хүлээж авлаа гэхэд Байнгын хороо засах үндэслэл байхгүй. Заавал энийг Засгийн газар санаачилж өөрчлөлт оруулах ёстой байхгүй юу. Энэ чинь Цэцийн энэ дүгнэлт чинь яадаг билээ.

Долоо хоног гэдэг чинь хэлэлцэж эхлэх хугацаа нь байдаг билүү? Шийдвэрлэнэ гэж үг байдаг билүү? Байнгын хороо ороод 7 хоногийн дотор л хэлэлцэнэ гэж байгаа тэ? Үгүй хэлэлцэнэ гэдэг үг байгаа тэ? Хэлэлцэж шийдвэрлэнэ гэдэг биш 7 хоногийн дотор хэлэлцэнэ гэсэн үг байгаа.

Тийм учраас би бол горимын санал гаргаад энийгээ ингээд хэлэлцээд эхэлчихсэн юм чинь энэ Засгийн газартай энийгээ ярих нь зөв байх. Ямар хэмжээнд байх юм. Албан ёсны байр суурь юмыг нь авч байж бид нар ярихгүй бол одоо энэ дээр чинь бид нар дахиад төсөв хэдэн тэрбумаар дутах вэ? Тэмүүлэн энэ татварыг ингээд зогсоочихлоо гэхэд. Бид нар энэ жилийн төсөв дээр энэ үлдэгдэл дээр энэ чинь явж байгаа шүү дээ тийм үү? Орлого талдаа энэ чинь бичигдээд л явж байгаа тэ? Тооцоо тал руу. Тэр хэмжээгээр бас төсөв чинь тасрах юм байгаан шүү дээ.

Тэгэхээр би энийг нь бол асууж байж оруулах ёстой юм болов уу л гэж би бодоод байгаа юм. Тийм горимын санал гаргах уу, эс үгүй бол хуралдаан даргалагч өөрөө шийдээд явах юм уу? Шийдэж байж холбогдох өөрчлөлт дээр л ярих болно шүү дээ. Энэ чинь шийд хүлээж авах эсэх нь шийдэгдээгүй шийдэж байж яана шүү дээ. Тэгж байж эхлээд шийдвэрээ гаргачхаад уу? Гэхдээ энэ

татварын ингээж тоо хэмжээ рүү ингээж ордог ер нь эвгүй шүү. Хүүхдийн мөнгө 100 мянга байгаа чинь буруу байна. 80 мянга болго гэдэг ч юм уу тиймэрхүү юм руу явна шүү. Үгүй тэр чинь бүүр Үндсэн хууль дээр байгаа.

**Б.Энхбаяр:** Баттөмөр гишүүн асуултаа асууя. Баттөмөр гишүүний микрофоныг өгөөрэй.

**Б.Баттөмөр:** Ингээд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт ирсэн байна. Энэ дээр нөгөө тэгш байдал гээд л янз бүрийн юм бичсэн л байна л даа. Тэгээд энд нэг их тийм тэгш байдалтай хамгийн гол нь биш л дээ. Энэ яг үйлдвэрлэж байгаа гэж байгаа энэ бүтээгдэхүүн маань өнөөдөр Монгол Улсын энэ дэлхийн стандарт Монгол Улсын стандартыг хангаж байна уу л гэдэг асуудал. Энд бол юу гэхээр тэр нөгөө эдийн засгаа зохицуулна гэсэн заалтыг зөрчсөн байна гэж байгаа юм.

Дараагийнх нь бол юу гэхлээр энэ бас нөгөө хүний нийгмийн асуудал. 5.4-ийг бас зөрчсөн гээд байгаа байхгүй юу. Тэгээд 5.4 нь юу гэхлээр зэрэг хүн амьд явах эрхтэй шүү дээ. Эрүүл орчинд амьдрах ёстой. Агаарын бохирдлыг цэвэрлүүлж байх ёстой гээд ингээд ийм Үндсэн хуулийн заалтуудтай шүү дээ. Тэгээд энэ тэрийг л би тооцож байж л энэ хуулийг баталсан юм болов уу, татварыг тогтоосон юм болов уу л гэж л ингээд бодож байгаа юм л даа. Энэ шатахуун нь асар их хэмжээний ийм хорт бодис ялгаруулдаг гэж байгаа юм. Тийм исэлдсэн хүхэр хувийн жин нь агаараас хүнд учраас нэг метрт ингээд цацагдаад тэгээд газарт хаягддаг. Хүний биед амьсгалах эрхтэнд асар их хорттой гэдэг. Энэ утгаараа бол тэр амьд явах эрхтэй аюулгүй орчинд амьдрах ёстой тэр агаарын бохирдлыг хамгаалуулах ийм эрхтэй гэдэг 16.1 16.2 дахь заалтуудыг л зөрчиж байгаа юм л даа. Би татварын асуудал энд ярихгүй л дээ. Үгүй одоо тэгээд ингээж болоод байдаг бол тэр их үйлдвэрийг энд тэнд барьж яадаг юм бэ? Энүүгээрээ л явъя л даа. Бид чинь тэр 1.5

тэрбум төгрөг доллароор Энэтхэгийн Засгийн газрын юугаар барьж байгаа шүү дээ. Тэрийгээ болиод өөр юм заръя л даа.

Би зүгээр Тэмүүлэнгээс ч юу ч асуугаад байх уу. Тэмүүлэн өөрийнхөө боломжоор хариулсан л байх л даа. Яг энэ нефть бүтээгдэхүүнийхээ энэ хаягдлыг ашиглаж шатахуун найруулж байгаа улс манай Монголоос өөр дэлхийд байдаг юм уу? Ганц ийм асуудал. Үг хэлэх юу байгаа тийм ээ. Энэ Үндсэн хуулийн цэц бол энэ асуудлыг авч хэлэлцэхдээ тэр бусад заалтуудтай нь тэр хүмүүс амьд явах эрхтэй, эрүүл орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцвэр алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэсэн энэ юунд би олон талаас нь сайн бодож л шийдвэр гаргасангүй л гэж ингээж бодож байгаа юм. Тэгээд би асуултдаа хариултаа авчихъя. Тэгээд үг хэлье.

**Б.Энхбаяр:** Тэмүүлэн гишүүн хариулах уу?

**Г.Тэмүүлэн:** Би сая Баттөмөр гишүүний асуултад тодорхой байр сууриа илэрхийлэх боломжгүй юм байна. Яг үндсэндээ бас энэ талаар ч нарийн сайн мэдээлэлгүй юм байна. Яах вэ зүгээр нэг талдаа манай аудитын байгууллагаас бол яах вэ аудит хийсэн байсан. Тэгээд энэ гол үндсэн дүгнэлт нь бол ерөөсөө төрөөс баримталж байгаа бодлого хуулийн хэрэгжилтийг иж бүрэн хангаж ажиллаагүйгээс газрын тосны завсрын нэмэлт бүтээгдэхүүнд тавих хяналт эзэнгүйдэж байна гэсэн ийм зүйл дүгнэлт гаргаад үүн дотроо бол яах вэ 2016 оноос хойш энэ завсрын бүтээгдэхүүний импорт өөрөө эрс нэмэгдсэн.

Тэр дундаа 2015 оны импортын хэмжээг 21 оныхтой харьцуулахад бол киросины импорт 10 дахин, хүнд фракцын нэгдлийн импорт 47 дахин өссөн байна гэсэн дүн гаргаж ирж байгаа юм. Тэгэхээр энэ өөрөө юуг харуулж байна вэ гэхээр өнөөдөр үндсэндээ дотоодод борлуулагдаж байгаа импортоор оруулж ирсэн бензин түшинээс энэ завсрын

бүтээгдэхүүн, магадгүй хэрэглэж, үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн бол асар их байна л гэсэн үг болчхож байгаа юм. Үндсэндээ манай бас энэ үе үеийн л бүх бодлогын баримт бичгүүдээр тусгагдсан зүйл нь бол үе шаттайгаар олон улсын стандартад нийцсэн бүтээгдэхүүнтэй болох гэдэг энэ асуудал бол байнга тавигдсаар ирсэн байгаа. Тэр дотроо Евро 5 стандартыг бол бид нар 2025 он гэхэд 50 хувьдаа хүргэх нийт чанартай бензинтэй байх үүгээр бол хэрэглэгчдийг хангах гэсэн ийм зорилтууд л ер нь дэвшүүлсэн байгаад байгаа юм. Тэгээд энийг ч гэсэн энэ Үндэсний аудитын газрын тайлан дүгнэлтэд бол тусгасан байна.

Цэцийн дүгнэлттэй холбогдуулаад яах вэ? Би бас дахиад л Мөнх-Оргил гишүүн ч гэсэн түрүүн асууж байсан. Хэлэхэд бол тухайн үедээ ч гэсэн Улсын Их Хурал хэлэлцэхэд Улсын Их Хурлын Тамгын газар хуулийн иж бүрдлийг бол бүрэн хангасан гэж үзээд угаасаа Улсын Их Хурал хэлэлцэж эхэлсэн. Цэцэд ч гэсэн гаргасан дүгнэлт дээр тэгж биччихсэн байгаад байгаа юм. Иж бүрдэл нь болж байгаа хэдий ч дотор нь байгаа ерөөсөө энэ агуулга нь ерөөсөө бүрэн судалгаагүй гарсан байна л гэсэн ийм л дүгнэлтийг хэлж байгаа юм.

Тэгэхээр яг одоо та бүхэн энэ Цэцийн гаргасан дүгнэлт дээр бас яг энэ үгийг нь бас дахиад нэг тодотгоод яах вэ уншаад үзье. Энэ тусгагдсанаар бол хуулийн төслийг холбогдох судалгаа бүрдүүлбэрийн хамт өргөн мэдүүлсэн байх боловч гэж байгаа юм. Тэгээд дүгнэлт судалгаа нь иж бүрэн бус бодит байдалд нийцээгүйгээж байгаа байхгүй юу. Дүгнэлт судалгаа нь тэгэхээр судалгаа нь бол бодит байдалд нийцээгүй дээрээс нь түүнчлэн хуулиар зохицуулах харилцаанд оролцогч талуудын эрх зүйн байдал болоод улс орны эдийн засагт хэрхэн нөлөөлөх асуудлыг тусгаагүй байна гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ судалгаан дотроо саяын энэ асуудлуудыг тусгаагүй байна оролцогч талуудын эрх ашиг болоод

эдийн засагт хэрхэн нөлөөлөхийг тусгаагүй байна л гэсэн энэ л зүйлийг хэлээд байгаа юм. Цэцийн дүгнэлт бол.

**Б.Энхбаяр:** Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяа:** Энэ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэ Онцгой албан татварын тухай хуультай холбогдуулсан дүгнэлтийг бид өнөөдөр хэлэлцэж байна. Энэ цэцийн дүгнэлтийг бол би дэмжиж байгаа хүн байгаа юм. Яагаад дэмжиж байгаа вэ гэхээр энэ аливаа улсын эдийн засаг бол өрсөлдөөний зарчмаар байх ёстой.

Өнөөдөр Монгол Улсын шатах тослох материалын зах зээлийг Оросын шатахууны зах зээл эзэлж байгаа. Энийг импортлодог компаниуд байдаг. Гэтэл өнөөдөр тэр барууны технологиор орж ирээд өнөөдөр тэр хуурамч шатахуун гээд байгаа энэ зүйлийг өнөөдөр хориглосон энэ асуудал энэ цэцийн дүгнэлт дээр байгаа компаниудад давуу байдал олгосон гэдэг энэ асуудал Үндсэн хуулийг баримталж шийдсэн л гэж ингэж ойлгож байгаа юм. Би яах вэ энэ анх энэ хуулийг өргөн барихад энийг дэмжиж баталсан хүний нэг. Тэгээд сүүлд өнөөдөр Монгол Улс энэ ковидын эдийн засгийн маш их хүнд байдалд ороод энэ бензин шатахууны үнийг буулгах асуудал 3 дахь зах зээлээс хамаарах асуудлыг бид өнөөдөр төрийн бодлогын хэмжээнд шийдэх ёстой гэдэг ийм шийдлийн үүднээс бас тодорхой хуулийг өргөн барьсан байгаа.

Тэгээд энэ судалгаа аваад ингээд явж байхад өнөөдөр би Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраар дамжуулаад төрийн өмчит бүх компаниудаас судалгаа авсан. Мөн энэ Байгаль орчин стандартын хэмжил зүйн газар судалгаа авсан. Энэ дээр бол өнөөдөр тэр хэвлэл мэдээллээр яриад байгаа өнөөдөр энэ мэдээлэл гаргаад байгаатай ер нь өөр ийм судалгаанууд

надад ирсэн байгаа. Би энийг Их Хурлын гишүүдэд би өгье гэж бодож байгаа.

Тэгэхлээр энэ өнөөдөр энэ нэг орны, нэг үйлдвэрлэгчийн хамааралд байдаг энэ асуудал өнөөдөр Монголчуудад ашигтай юу?

Гурав дахь, дөрөв дэх зах зээлээс бүтээгдэхүүн оруулж ирээд хамгийн хямд үнээр хэрэглэгчдэд хүргэх нь ашигтай юу гэдэг ийм сонголтыг л бид хийх ёстой. Ийм сонголт хийх ёстой. Тэрнээс биш өнөөдөр ингээд тэр Оросоос ирсэн нефтийн компаниудын нефть энэ байна. Энэнээс та авах уу, аль эсвэл бол тэр барууны технологиор өнөөдөр оруулж ирсэн тэр нефть бүтээгдэхүүнийг авах уу гэдгийг зах зээл дээр нээлттэй тавиад үнэхээр л ийм нөхцөлийг бүрдүүлж өгөх ёстой байхгүй юу. Тэрнээс биш өнөөдөр бид нар хараад байгаа шүү дээ, судлаад байгаа. Өнөөдөр хойд хөрш дайн болоод хамгийн их нефтийн үнэ унаад байдаг. Гэтэл өнөөдөр Монголд эсрэгээрээ нефтийн үнэ нэмэгдээд байна шүү дээ. Энэ технологи чинь зөв юм уу, буруу юм уу. Энэ бодлого чинь зөв юм уу буруу юм уу. Нэг компанид, нэг зах зээлд зориулсан бодлого чинь өнөөдөр Үндсэн хууль зөрчсөн байна л гэж ойлгож байгаа.

Ийм учраас би бол ийм байр суурьтай байгаагаа хэлье ээ. Асуулт байхгүй.

**Б.Энхбаяр:** Би нэг асуулт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуугаадахъя. Цэцийн үндэслэл хэсгийг уншихаар 2 юм байгаа юм. Нэгдүгээрт бол сая Мөнх-Оргил гишүүн асуусан. Энэ Хууль тогтоомжийн хуульд заасан шаардлагыг бүрэн хангаагүй гэдэг нэг ньюанс байгаа юм. Энүүгээрээ бол хууль дээдлэх зарчмыг алдагдуулсан гэж. Энэ 2 дахь үндэслэлээс нэг асуулт асуух гээд байгаа юм.

Хоёр дахь үндэслэл дээр нэг ийм юм байгаа юм. Гэтэл бүрэн бус судалгаанд үндэслэн татварын суурийг

өргөжүүлэхдээ газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосинд холбогдуулан онцгой албан татварыг шатлалгүйгээр тогтоосон нь түүхий эд импортлож байгаа үндэсний үйлдвэрлэгч нарт ялгамжтай байдал бий болгосон гэж байгаа юм. Энүүгээрээ тэгш байдлын зарчим тэр аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулах ёст заасныг зөрчсөн гэдэг дүгнэлт гаргасан байгаа. Энэ нь ямар учиртай юм бэ гээд дүгнэлтээс нь хайгаад үзэхээр нэг өргөдөл гаргагч иргэний гомдол дотор нэг ийм өгүүлбэр байгаа юм. Гэтэл Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эцсийн бүтээгдэхүүн буюу бензин дизель түли импортлогч нарт давуу байдал үүсгэж энэ юм нь татвар нь болохоор бензин дизель түли импортлогчдод давуу байдал үүсгэчихсэн гэж юм яриад байгаа байхгүй юу. Би бол энэ хуулийг батлахад дэмжиж санал өгч байсан юм.

Тэгээд энийг хамгийн их яриад байгаа нь жишээлбэл манай Баттөмөр гишүүн, Анандбазар гишүүн гээд нөгөө нефть импортлогчид байгаад байхгүй юу гишүүд. Энэ дээр болохоор энэ хүмүүс давуу байдал эсрэгээрээ Пүүжээ гишүүний хуульд давуу байдал олгосон гэж яриад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл нефть оруулж ирдэг хүмүүст давуу байдал олгосон гэж. Энэ яг юу хэлээд байгаа юм бэ? Би энийг нөгөө ойлгохгүй байгаад байгаа юм. Энэ яаж энэ Пүрэвдорж гишүүний энэ хууль нь Пүрэвдорж гишүүн бол энэ эсрэгээрээ Баттөмөр, Анандбазар 2-т энэ хуулийг санаачилж давуу байдал олгосон гэдэг юм энд яригдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр би энэ ньюансыг тайлж л ойлгомоор байна. Энэ яаж ийм энэ нь яагаад энэ хүмүүст давуу байдал болоод байгаа юм бэ гэдэг ч юм уу? Энийг би одоо нэг асуумаар байх юм. Энэ цэцийн энэ юунаас. Үгүй ээ итгэмжлэгдсэн төлөөлөгч л хариулна. Тэмүүлэн гишүүн.



**Б.Энхбаяр:** Цэцийн дүгнэлт дээр бас л яг энэ зүйлийг л харин бичээд байгаа юм. Тэгээд тухайн үед нэг талдаа энэ дайвар бүтээгдэхүүн завсрын бүтээгдэхүүн энэ керосинд холбогдуулж онцгой албан татварыг шатлалгүйгээр тогтоосон л гэдэг асуудлыг бас яриад байгаа. Нөгөө энэ гомдол гаргагч Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасан мэдээлэл өгсөн энэ хүмүүсийн зүгээс ч гэсэн бас энэ асуудлыг бол бас тавиад байгаа.

Тэгэхээр ерөөсөө энэ Цэцийн дүгнэлтээр бол газрын тосны бүтээгдэхүүн импортолж байгаа үндэсний аж ахуйн нэгжүүдэд бол нэг талдаа үүгээрээ бол давуу байдлыг бий болгож байгаа. Үүгээрээ бол илүү энэ импортын бүтээгдэхүүнийг дэмжиж байгаа гэдэг нь логик бол бас уншигдаад байна гэж хараад байгаа юм. Үндсэндээ Үндэсний аудитын газраас хийсэн бас энэ дүгнэлт дээр ч гэсэн ерөнхийдөө бол 2021 оны 8 сараас хойш татвартай болгосноос хойш энэ завсрын дайвар бүтээгдэхүүний импорт бол 3-аас 5 дахин дахин унасан байгаад байгаа юм.

Тэгэхээр ийм завсрын бүтээгдэхүүнүүд бол төдийлөн орж ирэхээ бол больсон л гэсэн үг л дээ. Энэ чинь тэгээд ер нь бол бид нарын хувьд гол энэ хуулийг анх гаргах асуудал маань ерөөсөө стандартын л асуудал. Нийт бид нар энэ импортолж байгаа шатахууныхаа 50 хувьд нь евро 5 стандартын шатахууны импортоор хэрэглээг нь дэмжинэ л гэсэн зорилго ерөөсөө үе үеийн манай газрын тосны салбарын бодлогод нь тусчихсан байгаад байдаг. Евро 5 гэдэг маань өөрөө юуг хэлж байна вэ гэхээр 95 бензинийг л хэлж байгаа.

**Б.Энхбаяр:** Гишүүд асуулт асууж дууслаа.

Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү?

Мөнх-Оргил гишүүнээр тасаллаа.  
Баттөмөр гишүүн үгээ хэлье.

**Б.Баттөмөр:** Энэ Монгол Улс нефть импортлох эрхтэй тусгай зөвшөөрөлтэй 300 аж ахуйн нэгж байдаг юм. Идэвхтэй үйл ажиллагаа яг оруулж ирдэг 30 аж ахуйн нэгж 1, 2 хүнд зориулж ингэсэн юм байхгүй байгаа гэдгийг би хэлье гэж бодож байна. Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаанд иргэд маш их шүүмжлэлтэй ханддаг. Шүүмжлэхээс өөр аргагүй л ийм байдал болсон юм байна л даа. Үндсэн хуулийн цэцийн дээр хөх тэнгэр байдаг гэж зарим хүн андуурдаг бололтой юм шиг байна. Үндсэн хуулийн цэцийн дээр Үндсэн хуулиар хамгаалагдсан Монголын ард түмэн байгаа. Ер нь Цэц бол орох орохгүй асуудал руу их ордог болсон гэж байгаа. Энэ бол төрийн эрх барих байгууллага Улсын Их Хурал өөрөө буруутай л юм байна л даа. Янз бүрийн сонирхлоор янз бүрийн юм оруулж ирдэг. Хуулийн цоорхой бид гаргаж өгөөд байгаа юм байна. Үндсэн хуулийн цэцийн энэ тухай хуулийн нөгөө цоорхойг засахгүй улс орны аюулгүй байдал, эдийн засгийн аюулгүй байдалд хар шийдвэр гаргаж болигүй болж байгаа юм. Улсын Их Хурлын итгэл үнэмшил итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр яах вэ хэн манай Тэмүүлэн ороод ярьсан байна лээ. Уг нь бол энэ Хууль зүйн байнгын хорооноосоо хүмүүсийг оруулаад энэ санаачлагч энэ тэрийг оруулаад ярьсан мэтгэлцээн илүү үр дүнтэй болох байсан юм болов уу гэж ингэж ярьж байгаа юм. Би энд бол энэ тарифын асуудал ярихгүй ээ.

Улсын Их Хуралд сонгогчдоо төлөөлж байгаагийн хувьд бүтээгдэхүүний чанар эрүүл ахуйн аюулгүй байдлын асуудлыг л би ярьж байна. Ер нь тэгээд энэ татвар тарифын асуудлуудыг энэ Цэц гаргаад шийдвэр гаргаад байдаг нь зөв ч юм уу буруу ч юм уу маш их хэмжээний НӨАТ, маш их хэмжээний татварын чөлөөлөлтийг яаж байна шүү дээ. Тэгш бус байдал үүсгэж байна гээд л ингээд л яваад байх уу үгүй

юу. Ер нь тэгээд явсаар байгаад төр бол эдийн засгаа зохицуулах Үндсэн хуулиар олгогдсон эрхээ ер нь хэрэгжүүлж чадах уу, үгүй юу гэдэг л ийм л асуудал гарч байгаа юм л даа. Онцгой албан татвар бол байгальд, хүн, байгальд сөрөг нөлөөтэй бараанд оногдуулдаг татвар шүү дээ.

Энэ хуурамч шатахуун гээд байдаг чинь юу юм бэ гэж байгаа юм л даа. Түүхий нефт нэрээд гардаг тийм хаягдал гардаг. Тэр нь керосин дагалдах бүтээгдэхүүн гээд янз бүрийн юмнууд хийдэг юм. Энэ керосин бүтээгдэхүүнүүдийг татваргүйгээр оруулж ирээд цэвэр шатахуун дээр хийж хольдог ийм технологи л байхгүй юу. Тэгээд стандартгүй, стандарт бус учир ингээд хуурамч гэж яриад байгаа юм. Энэ шатахууныг хольдог Монголд нэг л компани байгаа. Онцгой татвар төлдөггүй учраас хямдруулж дараа төлбөртэйгөөр бусдад заруулдаг. Нэг сэжигтэй нь бол бусад компаниудаар гаалийн бүрдүүлэлт хийлгэдэг. Энэ их тэрбумаар тоологдох энэ их мөнгө хаанаас эх үүсвэртэй нь тодорхойгүй. Монголын нэг жоохон залуу гарч ирээд тэрбум доллар гаргаж ирээд энэ шатахуун оруулж ирэх тийм мөнгө байхгүй шүү дээ Адьшаа гишүүнээ. Энэ бол явж байгаад энэ ФАТФ гээд нарийн юм руу орно шүү. Энийг одоо би өнөөдөр харууцлагатай хэлчихье.

Маш их хэмжээний сэжигтэй гүйлгээнүүд хийгдсэн байдаг юм байна. Энийг дарж байгаа хүмүүс ч байхгүй байсан. Ингээд энэ саванд хольж байгаа газрын тосны үйлдвэр гээд байгаа байхгүй юу. Нэг хэдэн сав барьчаад тэгээд хооронд нь холиод тэгээд ачдаг. Энийг одоо үндэсний үйлдвэрлэгч гэж Монголд байхгүй. Энэ өнөөдөр энэ Дорноговь аймагт газрын тосны үйлдвэр баригдаж байгаа юм. 2026 онд ашиглалтад орно гээд стандарт нийцсэн бүтээгдэхүүнийг энэ үйлдвэр л гаргана. Энэ бол анх Африкийн орнууд нэвтрээд хамгийн сүүлд Гондураст гэдэг улсад

ороод тэгээд хөөгдөөд дараа нь Киргизээс хөөгдөөд тэгээд сүүлд нь энэ Монгол, Киргиз, энэ Петролиум продакшин гэж Эрдэнэтэд байгуулагдаад тэгээд л ингээд явчихсан. Энэ бизнес яадаг вэ гэвэл ядуу буурай, авлигал ихтэй хуучин машиныг хэрэглэдэг орнуудад хэрэглэгдэж хөөгдсөөр байгаад л сүүлчийн орогнох газар нь Монгол болчихсон л байгаа.

Ингээд энэний хамгийн муу тал нь юу вэ гэхээр энэ дизель түлшээр ажилладаг машины түлшний аппарат, бензинээр ажилладаг машины карбератор эхлээд эвдэрдэг. Цаашиаад моторын шаталт дутуу явагддаг учраас цилиндр поршингийнх нь юмны хэмжээ гэхэд ингээд мотор жагсаалаас гардаг. Дэлхийн хэмжээнд ингээд судлаад үзэхээр АНУ-д 84 нефтийн үйлдвэр, ОХУ-д 121 үйлдвэр, БНХАУ-ад 64 үйлдвэр, Солонгос, Сингапур, Европын холбооны улсууд, олон 10 үйлдвэр, Хойд Солонгост хүртэл нэг үйлдвэр ажиллаж байгаа юм. Монгол, Бутан гээд нэг хэдхэн улсад нефтийн үйлдвэр байхгүй. Ингэж найруулж болдог юм бол дэлхийн энэ улсууд энэ олон үйлдвэр барьж яах юм. Энэ Энэтхэгийн Засгийн газрын тусламжтайгаар 1.5 тэрбум доллароор барих гэж байгаа энэ үйлдвэрийн ажиллагааг зогсоогоод энэ найруулдаг улсуудад нь эрхийг нь өгөөд тэр мөнгийг нь авчраад тэр эмнэлэг барья л даа. Энэ бол маш чухал асуудал шүү. Та нар олон талаас нь бодож иийдвэр гаргацгаагаарай. Энэ бол эдийн засгийн.

**Б.Энхбаяр:** Пүрэвдорж гишүүн үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр жоохон ширүүхэн ярьсанд уучлаарай.

Ер нь энэ хууль бол ямарваа нэгэн асуудал байхгүй. Бүрдүүлбэр энэ тэр нь бүгдээрээ хийгдсэн. Миний хуулийг бүрдүүлбэргүйгээр хүлээж авна эрх баригч нар байхгүй шүү дээ. Тийм учраас бүх материал энэ тэр бүх юм нь бүгдээрээ хангалттай байж байгаа. Засгийн газрын тэмдэглэл нь ч хүртэл байж байгаа.

Тэгээд бүх юмнууд нь байж байгаа. Мэдээж юу байдаг юм тэр law forim дээр тавьсан тэгээд тэрнийхээ дагуу судалгааны ажил хийгдсэн. Тэгээд бүх зүйл нь байж байгаа. Тэгэхээр энэ үнэхээр тэнд нэг ширхэг ч үйлдвэр байхгүй. Одоо тэгээд тэр Чойр дээр голцуу хольж байгаа. Үйлдвэрийг нь гаргаад ир л дээ. 230 мянган тонн керосин, нафта гэдэг юм л даа. Тэд нар чинь 230 мянган тонн орж ирээд зүгээр л ингээд нэг тийм сэнсээр л хольж байгаа байхгүй юу. Уул нь тоосруулж хольдог үйлдвэр. Үйлдвэр чинь тэгдэг байхгүй юу даа. Тоосруулж хольдог байхгүй юу даа. Гэтэл энэ чинь зүгээр ингээд хольчихоод зүгээр тэр байтугай байна шүү дээ тийм ээ. Эрдэнэт дээр 50 вагон орж ирлээ. Шатахуун ачсан. Тэгэнгүүт тэрэн дээр нь 25 хувийг нь ингээд соруулж авчхаад 75 хувийг нь үлдээхээд 75 хувь дээрээ 25 хувийг нь керосин хийчихээд дахиад 40 литр Хятадаас авчирдаг тийм бодис байдаг юм. Тэрийгээ хольчихдог юм. Тэгчхээд наашаа Улаанбаатар хот руу ирнэ шүү дээ. Хөдлөөд л урагшаа хойшоо явахаар тэгээд холигддог байхгүй юу даа. Тэгж хүртэл хийдэг юм шүү дээ. Үгүй юун үйлдвэр яриад байгаа юм бэ? Үгүй тийм хамаг юмаа эвдүүлж дуусааж байгаа шүү дээ. Энэ уул уурхайн том том тоног төхөөрөмжүүд чинь бүгдээрээ энэнээс болоод эвдэрдэг юм шүү дээ. Үгүй ээ, тэр юун үйлдвэр, ямар ч үйлдвэр байхгүй хөөе. Арай гайгүй нь юу байж магадгүй тэр Замын-Үүд дээр байгаа Транскейт гэж компани.

Өөр юу ч байхгүй наадах чинь ийм хачин юмыг ингээд сүүлдээ юу гэнэ вэ? энэ нэг 2 гишүүн надад ямар хамаатай юм? Би бол тэр Анандбазарт чинь аймаар дургүй. Би тэрэнтэй чинь ярьдаг ч үгүй. Тийм учраас энэ дээр үнэхээр хариуцлагатай хандахгүй бол тэгээд л хойтон тэр хар утаанууд нь хаяад л тэр замын хажуу талын шонгийн шон, гэрлийн шон, тэгээд л 50 метрээс доошоо тас хар болох юм бол тэгээд л та нар үр хүүхдээ тэр чигээр нь тэгээд л ерөөсөө ханиаднаас хүүхэд салахгүй байна шүү

дээ. Тэгээд л ерөөсөө сууриар нь тэр хүүхдийн эрүүл мэндийг ингэж байхгүй болгож байгаа хорт зүйл байхгүй юу даа. Тэгээд бүх хүмүүсийн машин тэргийг эвдэнэ. Тэгээд намайг яаж ч буруутгаж болно. Би нэг л зүйл байгаа. Ийм ард түмний хөрөнгө мөнгө эвдчихээд тэгээд улсын төсвийг хохироож 100, 100 тэрбум төгрөгийн ашиг олдог тэр компанийн өмнө л би бууж өгөхгүйн тулд өөрөөр хэлбэл би бас урт хугацаанд хэн нэгнээс энэ ямарваа нэгэн юмны өмнө бууж өгөхгүйн тулд л би энийг хийж байгаа юм.

Би энэ хуулийг л явуулсан юм. Бусдаар бол эд нар чинь ярьдаг юм миний найз нөхөд хамаатан садан зөндөө хүмүүсээр яриулдаг. Би хэзээ ч бууж өгөөгүй. Энэ Монголын ард түмний эсрэг юм байгаа юм. Монголын ирээдүйн эсрэг юм байгаа юм. Монгол хүний генд өөрчлөлт оруулахуйц тийм хорт бүтээгдэхүүнийг энэ хийж байгаа юм. Тэгээд дэлхийд ийм үйлдвэр байвал олоод ир л дээ хаана байна? Үгүй тэгээд одоо тэр юун дээр нь үйлдвэр байна уу? Очоод үз л дээ. Ямар ч үйлдвэр байхгүй шүү дээ. Яах вэ энэ нөгөө нэг Мэргэжлийн хяналт энэ тэр янз янзын байгууллагууд дүгнэлт гаргадаг юм. Тэртээ тэргүй керосин энэ тэр чинь тэрэн дотор холигддог бүтээгдэхүүн байхгүй юу. Тэр элементүүд нь байгаа учраас тэр нь асуудалгүй гардаг байх. Тэгэхдээ л энэ чинь стандарт бус шүү дээ. Үгүй хэлээд байна шүү дээ. Одоо тэр нөгөө зүгээр вагонд ингээд явж байхад нь тоормослоход л холиод тэгээд л зарж байгаа шүү дээ. Ийм стандарт гэж хаана байдаг юм. Дэлхийд байхгүй. Одоо бүгд ерөөсөө хамгийн сүүлд Киргизстанаас хөөгдөж гараад л энд ирсэн. Хэдэн Оросуудын хийдэг л бизнес шүү дээ.

**Б.Энхбаяр:** Мөнх-Оргил гишүүн үг хэлье.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа.

*Нарийн ширийнийг нь мэдэхгүй юм. Тэгэхдээ маш ойлгомжтой 2 л асуудал байна.*

*Хоёр тусдаа асуудал байна гэж би хараад байна.*

*Нэгдүгээрт энэ байна шүү дээ үнэхээр хүний эрүүл мэндэд хортой бол юун татвар тавих. Бид нар шууд хориглох ёстой шүү дээ тийм үү. Эхлээд энийг нэгдүгээрт энэ өнөөдөр энэ Цэцийн дүгнэлт хэлэлцсэнээс гадна энийг нэг мөсөн тогтоогоод нэг тийшээ болгомоор байгаа юм Энхбаяр дарга.*

*Тэгэхгүй тэгээд л хортойг нь мэдсээр байж татвар тогтоочихвол бид нар бас үүргээ биелүүлэхгүй л байна гэсэн үг шүү дээ тийм үү? Тэгэхлээр яг яриад байгаа шиг нь манай Пүрэвдорж гишүүний яриад байгаа бусад энэ нөгөө хуулийг санаачлагчдын яриад байгаа шиг үнэхээр хортой байна уу, үгүй юү гэдгийг тогтоогоод хортой байх юм бол шууд хориглоё. Тэр татварын тухай асуудал байхгүй. Тэгээд ийм байдлаар ажиллагаа явуулж байгаа бол эрүүгийн гэмт хэрэг тооцоод хариуцлага хүлээлгээд хүн хордуулсан хэрэгт нь тооцоод ингээд явъя. Хоргүй байх юм бол 2 дахь асуудал. Хоргүй байх юм бол татвараа төлөх л ёстой. Маш ойлгомжтой хялбархан л асуудал байна шүү дээ. Тийм ээ. Онцгой албан татвараас зугтааж тойруулж ийм ажил хийж байна. Тэрийг бол ямар ч тэнэг хүн хараад ойлгож байна. Хоргүй байх юм бол тэгвэл адилхан татвараа төлөөд яв. Ингээд л 2 салгаад л энэ асуудлыг шийдмээр байна. Яг өнөөдрийн Цэцийн дүгнэлтийн хувьд бол би цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй юм байна гэж тэр хувьдаа дүгнэж байгаа.*

*Яагаад гэвэл Цэцийн дүгнэлтдээ их тийм байх нь юанстай мөртөө тийм зальжин юм хийгээд хэлээд байгаа байхгүй юу. Хууль тогтоомжийн тухай хуулийн бүрдүүлбэрийг хангаагүй гэж нэг хэлчхээд. Тэгэхдээ нөгөө материалуудыг нь өгсөн боловч агуулгаараа тэр нь*

*шаардлага хангаагүй гэсэн юм яриад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл нөгөө Хууль тогтоомжийн хуулийн тавьсан шаардлагуудыг биелүүлсэн эсэхийг Цэц дүгнэх гээд байна шүү дээ. Агуулгын дүгнэлт хийгээд байна шүү дээ цэц тийм ээ. Агуулга үнэлээд. Тэгэхээр миний ойлгож байгаагаар бол Цэц Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн материалууд нь формын буюу процессын шаардлага хангасан байна уу, үгүй юү гэдгийг л Цэц хянах ёстой. Улаан, цагаан, Засгийн газраас дүгнэлт аваагүй эсвэл судалгаа тооцоо хийгээгүй тийм ээ. Ийм юм байх юм бол Цэц энэ дээр дүгнэлт гарч болох байх.*

*Тэгэхдээ би бас байх гэж хэлж байгаа юм шүү. Заавал болно ч гэсэн үг биш. Жишээ нь нөгөө нэг Цэц чинь 1999 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг тэгж хүчингүй болгосон шүү дээ. Агуулгыг нь хяналт хийгээгүй. Процессыг нь хянасан чинь процесс нь дутуу байсан байна гэж хэлээд тэгээд 2000 онд Их Хурал гарч ирээд процессыг нь гүйцээгээд оруулчихаар за одоо бидэнд хэлэх юм алга гэж хэлээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн шүү дээ. Тэрэнтэй адилхан процессыг хэлбэрийн хувьд хянаж болно уу гэхээс процессыг мөн тэр процесс дотор явж байгаа материалыг агуулгын хувьд Цэц бол хянах болж байхгүй.*

*Тэрийг бол Улсын Их Хурал өөрөө л хянана, нэгдүгээрт. Тэгээд энэ дээр юу гэдэг юм эдийн засагт нөлөөлөх асуудлыг тусгаагүй байна, тэр нь дутуу байна энэ тэр гэдэг бол Цэцийн дүгнэх ёстой асуудал биш. Тийм учраас энийг хүлээж авах бололцоогүй юм. Харин хүлээж авах боломжгүй гэдэг дүгнэлтдээ бид нар үндэслэлээ сайн гаргаж өгмөөр байна. Яг саяынх шиг ингээд процессын шаардлага биелүүлсэн байна. Агуулгыг нь та нар дүгнэлт хийхгүй шүү агуулгыг хянахгүй шүү энийг Улсын Их Хурал өөрөө хянана тийм ээ нэгдүгээрт.*



Хоёрдугаарт ер нь цаашидаа бид нар бодмоор юм байгаа юм. Энэ цэцийн маш олон дүгнэлт энэ хууль дээдлэх зарчим баримтлаагүй байна. Хууль дээдлэх зарчим нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг гээд Үндсэн хуульд заачихсан байгаа шүү дээ. Аягүй олон дүгнэлт тэгж гараад байгаа байхгүй юу. Тэгэхдээ Цэц тэрийгээ юу гэж ойлгоод байдаг вэ гэхлээр өмнө нь баталсан Улсын Их Хурлын хуультай энэ сүүлд баталсан хууль чинь зөрчилдчихсөн байна.

Тийм учраас дээдлэх зарчим алдагджээ гээд байгаа байхгүй юу. Тэгэхлээр энийг ч гэсэн бид нар энэ дүгнэлтдээ бүүр хэлээд өгчихмөөр байгаа юм. Тийм биш шүү.

Хоёр хууль хоорондоо зөрчилдөх бол хуулийн коллиз. Энэ бол байдаг л юм. Энийг бол цэц дүгнэх ёсгүй байхгүй юу. Хууль нь Үндсэн хуультай нийцэж байна уу үгүй юу гэдэгт л дүгнэх ёстой болохоос биш хууль дээдлэх зарчим гэдгийг 2 хууль хоорондоо зөрчилдөж байна гэдгээр ойлгож явцууруулж Цэц дүгнэж болохгүй л дээ.

Тэгээд энэ тайлбаруудаа хийгээд. Тэгээд энэ хар аа хамгийн гол нь энэ Үндсэн хуулийн яг ямар заалтыг зөрччихөөд байгаа юм бэ гэхлээр 1 дүгээр зүйлийн 2 буюу хууль дээдлэх зарчим. Сая би хэллээ шүү дээ.

Хоёр дахь нь 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг буюу нөгөө эдийн засгийн хөгжлийг одоо удирдан зохион байгуулна буюу төр нь нийтийн болон хувийн өмчийн энэ.

**Б.Энхбаяр:** Мөнх-Оргил гишүүнд нэмэлт нэг минут.

**Ц.Мөнх-Оргил:** Энэ 2 үндэслэл нь болохлоор сая 2.1-ийг ярьчихлаа. Хууль дээдлэх зарчим. 1 дүгээр зүйлийн 2-ыг ярьчихлаа хууль дээдлэх зарчим.

5 дугаар зүйлийн 4, төр нь эдийн засгийн аюулгүй байдал аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэсэн заалттай зөрчлөө гээд байгаа юм. Яг эсрэгээрээ байгаа байхгүй юу. Энэ чинь зохицуулах гээд ажиллаж байна шүү дээ тиймээ. Тийм байгаа биз бид нар чинь ялгавартай татвар тогтоож байна гэдэг чинь энэ гарцаагүй учраас ялгавартай тогтоож байна. Адилхан татварт ийм учир адилхан татвар тогтоож байна гэдэг чинь бид нар зохицуулж байгаа байхгүй юу. Энийг тавиагүй байсан бол харин энэ зохицуулах үүргээ биелүүлээгүй байна гэж Цэц бол бид нарт шаардлага тавьж болохоор байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ аль аль нь үндэслэл байхгүй байна аа. Тийм учраас бид нар Цэцэд цаашидаа ч гэсэн өөрсдөө Цэцээс нөгөө дүгнэлтийнхээ үндэслэлийг гаргаж өг гэж байнга шаарддагтай адилхан Цэцийн дүгнэлтийг хүлээж авлаа эсвэл Цэцийн дүгнэлтийг хүлээж аваагүй гэдэг Байнгын хорооныхоо.

**Б.Энхбаяр:** Цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явуулна. 6 санал хураалт байгаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82.2.2-т энэ хуулийн 82.2.1-д заасны дагуу Байнгын хороо цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл хэсэг заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулна гэж заасан.

Эхний санал хураалт.

Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн

4.1.5 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

81.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2. Хүлээн зөвшөөрч байна. Хүлээн зөвшөөрч байна 81.8 хувийн саналаар хүлээн зөвшөөрлөө.

2. Онцгой албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн 4.1.5 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал аж ахуйн бүх хэвилийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 81.8 хувийн саналаар хүлээн зөвшөөрлөө.

3. Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин нэг тонн гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тэгш байдал дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

81.8 хувийн саналаар хүлээн зөвшөөрлөө.

4 дэх санал хураалт.

Онцгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн хүснэгтийн 6 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин нэг тонн гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвилийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

72.7 хувийн саналаар хүлээн зөвшөөрлөө.

Тав дахь санал хураалт.

Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн, керосин нэг тонн 285 мянган төгрөг гэж заасан нь Монгол Улсын үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн тэгш байдал хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

72.7 хувийн саналаар хүлээн зөвшөөрлөө.

6. Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн 10 дахь заалтад газрын тосны үйлдвэрлэлийн дайвар бүтээгдэхүүн керосин нэг тонн 285 мянган төгрөг гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийн 4

дэх хэсгийн төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулья.

Санал хураалт 81.8 хувийн саналаар хүлээн зөвшөөрлөө.

Санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 4 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Адьшаа танилцуулна. Учрал гишүүн танилцуулчих уу? Учрал гишүүн танилцуулъя.

Гишүүд ээ, байж байгаарай гишүүд ээ. Монгол Улсын Шүүхийн

ерөнхий зөвлөлийн тогтоол ирсэн байгаа юм. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшүүлэгчийг томилуулах саналыг Улсын Их Хуралд танилцуулсан.

Намсрайн Батзоригийг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Улсын Их Хуралд танилцуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй гэсэн ийм тогтоол ирсэн. Манай байнгын хороо нөгөө Хяналт шалгалтын хуульд зааснаар сонсгол явуулах ёстой. Ингээд 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргах ёстой байгаа юм. Тэгэхээр би албан бланк дээрээ хүсэлт гаргачихъя. Гишүүд маань бас энийг дэмжээд зураад өгчхөөрэй гэж би хэлэх гэж байгаа юм. Ингээд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ  
П.МЯДАГМАА